

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2018 - 12 сар | Дугаар 2

ГАРЧИГ

2-3 Анхдагч зах зээлийн арилжаанд хувьцааны захиалга хэд дахин биелдэг. Харин хоёрдогч зах зээлд хувьцааны ханш уначихдаг.

5-6 “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форум боллоо.

7-8 Төрөөс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэдэд хуваарилсан 1072 хувьцааг хоёрдогч зах зээлд гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг сүүлийн үед нэлээд эрчимжүүлж байна. Үүнд СЗХ ямар үүрэгтэй оролцож байгаа вэ?

9-10 МУТСТ чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам

12 Телематик даатгал

13 Блокчейн ба давхар даатгал

15-18 Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг үнэлэх түүвэр судалгаа

19 “Хүртээмжтэй даатгалын туршлага солилцох форум” (MEFIN)

20-21 Өргөн дуран

23 Зах зээлийн мэдээ

С.Даваасүрэн:

ХҮМҮҮСТ ИЛҮҮ ӨРГӨН СОНГОЛТ ӨГӨХ НЬ ХӨГЖИЛ МӨН

Санхүүгийн зохицуулах хорооны (СЗХ) дарга, доктор С.Даваасүрэн 2018 оны санхүүгийн салбарт гарсан гол үзүүлэлтүүд, өөрчлөлтүүд, тэдгээрийн учир шалтгааныг сэтгүүлчдэд танилцуулсан юм. Түүний яриаг хүргэж байна.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн МУИС (бакалавр), Английн Манчестерийн их сургууль (магистр), АНУ-ын Нью Хемпшир дэх Их сургуульд докторын зэрэг тус тус хамгаалсан. МУИС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш, Дэлхийн банк, АХБ-нд зохицуулагч, зөвлөх, Олон улсын хөрөнгө оруулалтын корпорацид шинжээч, 2014-2016 онд МАН-ын даргын эдийн засгийн бодлогын зөвлөхөөр тус тус ажиллажээ.

Ядуурлыг бууруулах, орлогын дахин хуваарилалт, тэгш бус байдал, хөрөнгийн зах зээл дэх амьгүй хөрөнгийг хэрхэн амь оруулах, хөгжиж буй орнуудын эдийн засаг зэрэг сэдвээр 20-оод жил судалгаа хийжээ.

–Намайг 2016 оны долдугаар сард энэ ажлыг хүлээн авахад СЗХ 130 гаруй ажилтантай, 29 даргатай байсан. Гурван хүн тутмын нэг нь дарга байсныг өөрчилсөн. Дарга нарыг чиглэлийн ахлахууд болгосон юм. Үүнтэй эвлэрээгүй зарим хүн ажлаа өгсөн. Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар, Мэдээллийн технологийн хэлтсийг шинээр байгуулж, ажлаа эхэлсэн.

Би 22 жил төрийн үйлчилгээний албанд багшаар ажилласан. Төрийн жинхэнэ албан

хаагчаар сүүлийн хоёр жилд л ажиллаж байна. Харамсалтай нь зарим төрийн албан хаагчдад чадвар эсвэл сэтгэл дутаж байна. Мөн олж авсан мэдээллээ өөрийн давуу тал гэж бодон, мэдээллийг хуваалцах сонирхолгүй албан хаагч байна.

2016 онд ББСБ-ын тоо 2015 оноос ихээхэн өсөж, 519 болсон байв. Мөн шинээр тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлүүд овоорсон. Иймд бид хоёр ч удаа тусгай зөвшөөрөл олголтоо түр саатуулсан. ББСБ-ын дүрмийн сан 400 сая төгрөг байсныг 800 сая төгрөг

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

📍 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.

☎ 976 51 261611

✉ press@frc.mn

🌐 www.frc.gov.mn

📍 Санхүүгийн зохицуулах хороо

📍 @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

болгож нэмсэн. Үүнд нь ББСБ-ууд ихээхэн бухимдалтай байсан үе.

“Анхдагч зах зээлийн арилжаанд хувьцааны захиалга хэд дахин биелдэг. Харин хоёрдогч зах зээлд хувьцааны ханш уначихдаг”

Мөнгөний бодлогыг Монголбанк, төсвийн бодлогыг Сангийн яам тодорхойлон хэрэгжүүлдэг. Санхүүгийн салбарын бодлогыг СЗХ тодорхойлон хэрэгжүүлэх учиртай. Гэвч энэ байгууллага өнгөрсөн хугацаанд тусгай зөвшөөрлийн хүсэлтийг ААН-үүдээс хүлээн авч, бүртгэх ажил голдуу хийсээр ирсэн. Бодлоготой больё гээд бодлоготой болчихдоггүй. Өнгөрсөн хугацаанд юу болов, цаашид юу хийх вэ гэдгийг шийдэхийн тулд судалгаанд үндэслэх ёстой. Гэтэл судалгааны архив хангалттай байгаагүй. Иймд Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийг шинээр байгуулсан юм. Сүүлийн хоёр жилд манай судлаачид 50 орчим судалгаа хийгээд байна. Мөн бид хэрэглэгчийн итгэлийн индексээс зах зээлийн хүлээлтийн талаарх мэдээллийг тогтмол авч байна.

Хоёр жилийн өмнөхийг эргээд санавал тухайн үед зээлийн олдоц багассан байв. ББСБ-ууд улам л ломбард шиг болж байсан. Нэг ББСБ-д дунджаар хоёр хүн ажилладаг, нэг хүн хэд хэдэн ББСБ-ын тусгай зөвшөөрөл эзэмшсэн. Иймд ББСБ-ын дүрмийн санг дөрвөн жилийн хугацаанд үе шаттай өсгөх, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг бол 2.5 тэрбум төгрөг болгох шийдвэрийг гаргасан. Маргаашаас нь намайг, биднийг тэнэг мангуугаар нь олон удаа дуудсан. Бид гурван сарын турш энэ шийдвэрийн үндэслэлээ тайлбарласан юм. Гэсэн ч ББСБ-ын тоо дахин өсөх хандлага байна.

Дараа нь даатгалын компаниудын дүрмийн санг мөн өсгөх шийдвэр гаргасан. Өмнө нь ийм шийдвэр гарсан ч оролцогчид биелүүлээгүй байсан юм. Хууль өөрчилнө гэлгүйгээр СЗХ өөрт байгаа эрхийн хүрээнд журмаа өөрчлөх замаар даатгалын компаниудын дүрмийн санг 5.0 тэрбум төгрөг болгосон.

2017 оноос эхлэн бид хөрөнгийн зах зээлд анхаарч эхэлсэн. Хаалгыг нь нээгээд үзтэл өмч хувьчлалтай холбоотойгоор энэ салбарын бодлого, зарчим, үйл ажиллагаа нь тодорхой бус байв. Феодализмаас шууд

социализм руу харайсан, капитализмыг алгасаж байна гэсэн утгатай, морь унасан хүний зураг өмнөх нийгмийн үед хаа сайгүй өлгөөтэй байдаг байсан даа. Та нарын хэд нь тэр зургийг мэдэх бол. Яг л тийм дүр төрх харагдсан. Хүмүүс ойлгоогүй байхад ягаан, цэнхэр тасалбар олгон, өмч хувьчлалыг явуулсан шүү дээ. 457 улсын үйлдвэрийг хувьд шилжүүлсэн. 2008 онд СЗХ эдгээр ХК-ийн 168-ыг нь бүртгэлээс хассан юм билээ.

ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД ХУВЬЦААНЫ ХАНШ УНАДАГ НЬ ХЭНИЙ СОНИРХОЛ ВЭ?

Өнгөрсөн хугацаанд СЗХ хамгийн чухал хэсэг болох үнэт цаас, хөрөнгийн зах зээлээ хойш тавиад, ХЗХ, ББСБ-тай илүү зууралдсан байсан. Хөрөнгийн захад ямар бүтээгдэхүүн байна вэ гээд хартал дийлэнхийг нь Засгийн газрын бонд зээлж байв. 2011 онд манай эдийн засаг 17 хувьд хүрч цойлсон үед хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2.0 их наяд төгрөгт хүрч өссөн. 4.6 тэрбум америк доллараар гадаадын шууд хөрөнгө оруулалт өссөн нь үнэлгээг дээш татсан. Түүнээс хойш зах зээлийн үнэлгээ унасаар 2015 онд 1.2 их наяд төгрөг болжээ.

“Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээлийг хөндөөгүй хэрнээ Хөрөнгийн биржээр хамгийн их оролдсон”

2015 оноос хойш Сангийн яам Засгийн газрын бонд арилжаалаагүй. Гэсэн ч хөрөнгийн зах зээл сүүлийн гурван жилд 200 хувиар буюу дотоод нөөц боллоцоогоороо өссөн. Учир нь гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ салбарт байгаагүй. 2016 онд ажлаа авснаас хойш бид нэг давхар бүртгэл хийн (“Эрдэнэ ресурс девелопмент” ХК), компанийн хоёр бонд гарган, долоон IPO хийжээ. Гэсэн ч биднийг удаан ажиллалаа гэх шүүмжлэл гардаг.

Шинэ хувьцааг анх удаа арилжаалахад брокер дилерийн компаниуд, андеррайтераар ажилладаг компаниуд нийт үнийн дүнгийн 5–6 хувийг шимтгэл болгон хувьцаа гаргасан компаниас авдаг. Иймд тэд аль болох хурдан арилжаа эхлүүлэхийг хүсэх нь тодорхой. Гэхдээ та нар ажигласан бол анхдагч зах зээлийн арилжаанд хувьцааны захиалга хэд дахин биелдэг. Харин хоёрдогч зах

зээлд хувьцааны ханш уначихдаг. Энэ хэний сонирхол вэ?

Компаниуд урт хугацаатай, зардал багатай санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татах хүсэлтэй. Харин хөрөнгө оруулагчид богино хугацаанд ашиг хүртэх сонирхолтой байна. Эдийн засагт тодорхой бус зүйл их тул хувьцаа эзэмшигчид урт хугацааны хөрөнгө оруулалт хийхгүй байна. Үүнд хувьцаат компаниуд ногдол ашиг олгохгүй, эсвэл бага олгодог зэрэг нөлөөлдөг. Эдийн засгийн онолоор хүн хамгийн рационал буюу ухаалаг шийдвэр гаргадаг тул хөрөнгө оруулагчдыг буруутгах аргагүй. Үнэлгээчид, аудитууд, брокер дилерийн компаниуд ч мэргэжилтнүүдийнхээ мэдлэг, ур чадварыг сайжруулах шаардлага бий. Тэд энэ салбарын дэд бүтцийг бүрдүүлдэг.

Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээлийг хөндөөгүй хэрнээ Хөрөнгийн биржээр хамгийн их оролдсон юм билээ. Зүйрлэвэл, хөгшин юм уу, залуу юм уу гэдэг нь тодорхойгүй хүн шиг болчихсон. Хөрөнгийн биржээс гадна Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Арилжааны төлбөр тооцоо гэж тусдаа байгууллагууд бий. Бүгд тус тусдаа захиралтай. Хөрөнгийн биржид төлбөр тооцооны системийг 2011 онд Их Британиас худалдан авч нутагшуулсан атлаа Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй

энэ талаар зөвлөөгүй. Одоо ч нэг нь ягуартай, нөгөө нь морин тэрэгтэйгээ л байна.

ИДЭВХГҮЙ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ НӨЛӨӨЛДӨГҮЙ

Олзуурхууштай нь СЗХ шаардлагатай хуулиудыг батлуулж чадсан. Өнөөдөр санхүүгийн салбарын үйл ажиллагааг 17 хууль, 170 орчим журмаар зохицуулж байна. Ер нь аль ч салбарт төрийн зохицуулдаг байгууллагадаа дуртай зохицуулагддаг байгууллагууд байхгүй. Харин эдгээр байгууллагууд эвсэж нэгдвэл асуудал байна гэсэн үг. Ерөөсөө л зохицуулагч байгууллагуудын жишиг ийм юм.

“СЗХ зөвхөн бүртгэх биш, энэ салбарт болохгүй байгаа зүйлсийг засах зорилгоор компаниудад өндөр шаардлага тавьж ажилласнаар эхний өөрчлөлтүүд гарч байна”

Андеррайтингийн компаниудын дүрмийн санг өсгөх шийдвэрийг СЗХ-ны өмнөх удирдлагууд бас л гаргасан. Гэвч энэ салбарын холбооны хүсэлтээр хэд хэдэн удаа хойшлуулаад, одоог хүртэл мөрдөж эхлээгүй

байна. Уг нь төр маш сайн судалсны дараа шийдвэрээ гаргадаг, тэр шийдвэр гарсан л бол хэрэгжих ёстой.

Хөрөнгийн зах зээл, даатгал, ББСБ гэх мэт олон салбарын тоон үзүүлэлтүүд өнгөрсөн оноос хойш өсөж байна. Үүнийг эдийн засаг угаас сэргэж, идэвхжиж байгаагийн илрэл гэж зарим хүн тайлбарладаг. Иймд бид эдийн засгийн өсөлт үнэхээр нөлөөлсөн үү гээд судлахад шууд хамаарал байгаагүй. Идэвхгүй санхүүгийн зах зээлд эдийн засгийн өсөлт нөлөөлдөггүй юм байна. Харин идэвхтэй, хөрвөх чадвар сайтай бол хүчтэй хамаарал бий гэдгийг тогтоосон. Үүнийг би юу гэж дүгнэж байна гэхээр СЗХ зөвхөн бүртгэх биш, энэ салбарт болохгүй байгаа зүйлсийг засах зорилгоор компаниудад өндөр шаардлага тавьж ажилласнаар эхний өөрчлөлтүүд гарч байна.

Бид өгөгдсөн боломждоо тулгуурлан, хамгийн өндөр бүтээмж гаргахыг зорьсон. Хүмүүст илүү өргөн сонголт өгөх нь хөгжил мөн. Иймд санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүний тоо төрлийг өсгөхөд ихээхэн анхаарна.

Б.Чимэг

Эх сурвалж: www.gogo.mn

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДСАН ЖУРМУУД ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛЛО

Санхүүгийн зохицуулах хороо банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдүүлж буй журам, заавруудаа шинэчлэн сайжруулах, боловсронгуй болгох ажлыг сүүлийн жил гаруйн хугацаанд үе шаттай хийж байна. Энэхүү ажлын хүрээнд эцэслэн боловсруулж, Хорооны энэ оны 9 дүгээр хурлаар хэлэлцүүлэн баталсан даатгалын зах зээлийн зарим журам, заавар, хэлбэр болон стандарт, загварыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлээ.

Хорооны 2018 оны 207, 208, 210, 211, 212, 213 дугаар тогтоолуудаар шинэчлэн баталсан “Сайн дурын даатгалын хэлбэр”, “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”, “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”, “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар”, “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ыг дээрх санд бүртгүүлснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ АЛХАМ БОЛОХ ИРО-УУДЫГ ЗӨВШӨӨРӨВ

Санхүүгийн зохицуулах хороо 2018 оны 8 дугаар сарын 29-ний хуралдаанаар “Ард даатгал” ХК-ийн 25.0 сая ширхэг, “Мандал даатгал” ХК-ийн 6.2 сая ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд тус тус бүртгэлээ. Бүртгэлд авсан хувьцаанаас “Ард даатгал” ХК 30 хувь буюу 7.5 сая ширхэг, “Мандал даатгал” ХК 25 хувь буюу 1.6 сая ширхэг хувьцааг тус тус нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрөв.

ЕСБХБ–ТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИНЭ ТӨСӨЛ ЭХЭЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо Европын сэргээн босголт, хөгжлийн банк /ЕСБХБ/-ны санхүүжилтээр “Монгол Улсын хөрөнгийн зах зээлд төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) болон Т+2/3 зарчмыг нэвтрүүлэх” төслийг хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү төслөөр үнэт цаасны төлбөр тооцооны тогтолцоог шинэчилж, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нэгдсэн системийг бий болгох юм. Төслийн хүрээнд Сангийн яам, Монголбанк, биржүүд, АТТ, ҮЦТХТ, кастодиан банкууд, брокеруудтай хамтран ажиллаж байна.

Төслийн зөвлөх багтай уулзсан эхний уулзалтаар Хорооны зүгээс үнэт цаасны төлбөр тооцооны дэд бүтцийн байгууллагуудын санхүүгийн чадавхыг сайжруулах, батлан даалтын сан үүсгэх, манай зах зээлд нийцсэн төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) болон Т+2/3-ын зарчмын тодорхойлох, мэдээллийн технологийн нэгдсэн систем бүхий дэд бүтцийг бий болгох зэрэг төслийн хүрээнд хийх, эцэслэн шийдвэрлэх шаардлагатай ажил, асуудлуудыг танилцуулсан юм.

Зөвлөх багийн зүгээс эхний ээлжинд манай улсын санхүүгийн салбарт хамаарах төрийн байгууллагууд болон хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд, зах зээлд оролцогчидтой биечлэн уулзсан бөгөөд, мэдээ мэдээллийг цуглуулан дүгнэлт хийж, мөн өөрийн туршлагад тулгуурлан шаардлагатай зөвлөмжийг боловсруулаад байна.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНД ХЗХ–ДЫГ ХАМРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо зах зээлд оролцох, үйлчилгээ авахад иргэдэд учирч байгаа саад бэрхшээлийг бууруулах, тэгш

боломжоор хангах зорилтынхоо хүрээнд хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)–дыг Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулахаар ажиллаж байна. Ингэхдээ санхүүгийн зах зээлд оролцогчдод тавигдах нөхцөл, шаардлагыг үйл ажиллагааны онцлогтой уялдуулан оновчтой тогтоох, хөнгөвчлөх арга замыг холбогдох байгууллагуудтай хамтран эрэлхийлж байна.

Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг батлан даах үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага юм. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд, Зээлийн батлан даалтын сан нь банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргана гэж заасан. Тодруулбал, сангийн үйл ажиллагаа нь жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах, сангийн үйл ажиллагааг оновчтой үр ашигтай явуулахад оршдог юм.

“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ II ҮЕ ШАТНЫ ТӨСӨЛ”–ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛД ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ



Санхүүгийн зохицуулах хороо 2018 оны 10 дугаар сарын 19–ний өдөр Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)–тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж буй техникийн хамтын ажиллагааны “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”–ийн цар хүрээ, үйл ажиллагаа, хүлээгдэх үр дүнг тохиролцсон хурлын тэмдэглэлийг албажууллаа. Хурлын

тэмдэглэлд Хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн, ЖАЙКА–гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мүцүми Сато нар гарын үсэг зурав.

“Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”–ийг төлөвлөх уулзалтуудыг ЖАЙКА–гийн ахлах зөвлөх Цүнода Жиро, Төрийн бодлого, санхүүгийн салбарын хэлтсийн орлогч дарга Огата Эрина нар Хороо болон Сангийн яам, Монголбанк, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын үнэт цаасны бирж” ХХК, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон бусад холбогдох байгууллагад хийсэн юм. Уулзалтуудаар II үе шатны төслөөр гүйцэтгэх ажлын хүрээг, компанийн бондын зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөгөө өгөх, зэрэглэл тогтоох байгууллага байгуулах болон биржийн бус арилжааны эрх зүй, зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлж боловсруулах, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх гэсэн гурван чиглэлээр тогтоогоод байна. Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл 2019 оны эхний улирлаас гурван жилийн хугацаанд хэрэгжинэ.

ОЛОН УЛСЫН БИЧИЛ ДААТГАЛЫН ЧУУЛГАНД ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны Хянан шалгагч Б.Болор Олон улсын бичил даатгалын чуулган (ОУБДЧ, International Microinsurance Conference)–ы “Улс хоорондын мэдлэг солилцоог дэмжих болон Хүртээмжтэй даатгал дахь зохицуулагч байгууллагуудын санал бодол” сэдэвт хуралдааны үндсэн илтгэлийг тавьж, панелистаар ажиллалаа. Бүгд Найрамдах Замбиа улсын нийслэл Лусака хотноо зохион байгуулагдсан уг чуулганд 50 гаруй улс орны даатгалын зах зээлд ажиллаж буй 450 гаруй судлаач, мэргэжилтэн оролцсон юм.

Замбиагийн Бичил даатгалын техникийн зөвлөл (Microinsurance Technical Advisory Group of Zambia (TAG)) болон Мюнхен ре сан (Munich Re Foundation), Бичил даатгалын хамтын ажиллагаа (Microinsurance network–MiN)–тай хамтран зохион байгуулсан тус чуулганд оролцогчид салбарын өнөөгийн

төлөв болон цаашдын хөгжлийн чиг зам ямар байх, дараагийн алхмууд ямар байх талаар санал солилцож, “Бичил даатгал улс орны хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ”, “Латин Америк болон Карибын тэнгисийн орнууд дахь бичил даатгалын зах зээл, түүний өнөөгийн байдал”, “Технологийн дэвшил ирээдүйн бичил даатгалын салбарт хэрхэн нөлөөлөх вэ” болон “Дижитал технологи болон мобайл даатгал” сэдвүүдээр нэгдсэн хэлэлцүүлгүүдийг явуулсан байна.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ БАТЛАГДЛАА

Улсын их хурлаас энэ оны дөрөвдүгээр сард “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо хуулийн хэрэгжилтийг хангуулах мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам, заавар батлах эрхийг хуульчилсан ба захиргааны хуульд нийцүүлэн боловсруулах шаардлага урган гарсан билээ.

Тиймээс Хороо “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг боловсруулан баталлаа. Энэхүү журмын зорилго нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 4.1.2–4.1.7–д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд уг хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, заавраар хүлээсэн хэрхэн хэрэгжүүлж байгаад зайнаас болон газар дээр нь хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахад чиглэв.

SANDBOX-ЫГ СУДАЛЖ БАЙНА

Санхүүгийн салбар уламжлалт үйлчилгээнээс халин, технологид суурилан хөгжих хандлагатай болсон өнөө үед Санхүүгийн зохицуулах хороо олон улсын хэмжээнд гарч буй зах зээлийн хөгжлийг дэмжихүйц зохицуулалтын арга хэрэгслүүдийг судалж байна. Дэлхий дахинд санхүүгийн

зохицуулалтад түгээмэл хэрэглэгдэж буй сүүлийн үеийн технологи бол Сэндбокс (Sandbox) юм.

Санхүүгийн салбар нь онцлогоосоо хамааран нарийн чанд сахилга бат, зохицуулалтын хүрээнд явагддаг. Асар хурдацтай хөгжиж буй ФинТек /санхүүгийн технологи/-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эрчимтэй өсөн нэмэгдэж буй энэ үед тэдгээрийн зохицуулалт мөн хурдтай, уян хатан байх шаардлагатай. Зах зээлд гарч ирж буй шинэ санаачилга, дэвшилтэт бүтээгдэхүүнийг мэдээллийн нэг урсгалаар хянан, зохицуулснаар тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний сул тал, эрсдэлийг багасгах, эрх зүйн болон бизнесийн стандарт, шаардлагуудад нийцүүлэх боломжуудыг тооцоолж, ФинТек-ийн хөгжилд дэмжлэг үзүүлдгээрээ Сэндбокс давуу талтай. Энэ нь эргээд зах зээлд санхүүгийн хүртээмжийг сайжруулах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ФОРУМААР ФИНТЕКИЙГ ХЭЛЭЛЦЛЭЭ



БНСУ-ын Сөүл хотноо 2018 оны 12 дугаар сарын 4–ний өдөр зохион байгуулагдсан “Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны форум” (International Financial Cooperation Forum)–д Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгчид урилгаар оролцлоо. “Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд финтекийг ашиглах нь” сэдвийг хэлэлцэж буй уг форумыг БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороо (Financial Services Commission) болон Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны зөвлөл (ОУСХАЗ, Council on International Financial Cooperation) хамтран зохион байгуулсан юм.

Финтекийн дэвшлүүд, тэдгээрийн

нөлөөллөөр асар хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй санхүүгийн зах зээлд хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх болон зохицуулалтын ямар дэвшилтэт боломж байж болохыг улс орнуудын туршлага, сорилт, ололт амжилтад тулгуурлан хэлэлцэж буй энэхүү форумд Хорооны төлөөлөгчид Монгол Улсын санхүүгийн зах зээлд нэвтэрч буй финтекийн шийдлүүд, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлууд болон үзэл баримтлалыг танилцуулав.

“САНХҮҮГИЙН САЛБАРЫН КОМПЛАЕНС 2018” ФОРУМ БОЛОО



Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж, зээлийн хоршооны, үнэт цаасны болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын зах зээлийн мэргэжлийн холбоодтой хамтран “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумыг зохион байгууллаа.

Форумыг нээж УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны дарга Д.Дамба-Очир, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн нар үг хэллээ.

Байнгын хорооны дарга Д.Дамба-Очир, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-үүдэд тусгагдсан Хорооны зохицуулалттай зах зээлүүдийн нийт санхүүгийн салбарт эзлэх хувийг 10–15 хувьд хүргэх зорилтод форумын үндсэн сэдэв болох комплаенсыг хэрэгжүүлэх нь чухал нөлөөтэйг дурдсан бол Хорооны дарга, доктор С.Даваасүрэн комплаенсын үйл ажиллагааг санхүүгийн салбаруудад нэвтрүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх чармайлт, хамтын хүчин зүтгэл чухал болохыг онцлов.

Тэрээр энэхүү форумыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, баримтлах бодлого, чиг хандлагаа тодорхойлдог байх зорилт тавин ажиллаж байгаагаа мэдээллээ.



“Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумд нийт 250 орчим зочид, төлөөлөгчид оролцсон бөгөөд нэгдсэн болон салбар хуралдаануудаар хэлэлцсэн комплаенсын зарчмуудыг нэвтрүүлэхтэй холбоотой санал дүгнэлтүүдийг нэгтгэж, санхүүгийн салбарын дотоод хяналтын уламжлалт арга ажиллагааг комплаенсын орчин үеийн жишигт нийцүүлэн шинэчлэх, олон улсын стандарт, хэм хэмжээг нэвтрүүлж мөрдүүлэх, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороо мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, сургалт, арга зүйгээр хангах, сурах бичиг, гарын авлага болон холбогдох баримт материалыг боловсруулах, зохицуулалтын журам, зааврыг батлан мөрдүүлэх зэрэг тодорхой ажил, алхмуудыг тусгасан зөвлөмж гаргахаар боллоо.

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД, ИНСТИТУТУУД БОЛОН ТББ-УУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо зарим мэргэжлийн холбоод, институтууд болон төрийн бус байгууллагуудтай хамтран



ажиллах гэрээ байгуулж, гарын үсэг зурлаа.

Санхүүгийн зохицуулах хороо 2018 оны 9 дүгээр сард ҮЦАЭХ, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттай Хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хороо болон холбоо, институтуудын хамтран ажиллах гэрээнд үнэт цаасны зах зээлийн харилцааг шинэ шатанд гаргах буюу биржийн бус зах зээлийг хөгжүүлэх, үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчид, санхүүгийн зуучлагчдын чадавхыг нэмэгдүүлэх буюу мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх, сургалтыг мэргэжлийн түвшинд, чанартай зохион байгуулах харилцааг тусгасан байна. Түүнчлэн Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөг гарган ажиллахаар тохиролцов. Мөн Хороо болон холбоо бодлого зохицуулалтын ба өөрийгөө зохицуулах байгууллагыг бэхжүүлэх, гишүүдийг чадавхжуулах чиглэлд ил тод, нээлттэй, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд

тулгуурлах зарчмыг баримтлан ажиллахаар харилцан үүрэг хүлээлээ.

Санхүүгийн зохицуулах хороо 2018 оны 12 дугаар сард Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ, Монголын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчдийн нийгэмлэг, Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо, Монголын хуульчдын холбоо нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Хороо нь дээрх байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах, судалгаа хийх, гадаад орны туршлага судлах, зах зээлд оролцогчдын мэргэжлийн ёс суртахууныг сайжруулах зэрэг болон бусад олон чиглэлээр хамтран ажиллах юм.



ХУВЬЦААГ АРИЛЖААЛЖ ЭХЛЭХЭД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЛХМУУДЫГ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын орлогч дарга Б.Долгорсүрэнтэй “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн 1072 хувьцааны талаар товч ярилцлаа.

–Үнэт цаасны зах зээлийг СЗХ хянан зохицуулдаг. Тэгэхээр аливаа хувьцаа, хувьцааны зах зээл, үнэт цаас гаргах болон анхдагч, хоёрдогч арилжааг эхлүүлэх нь танай хорооны асуудал. Эрдэнэс–Таван толгой ХК-ийн 1072 хувьцааны талаар СЗХ өнгөрсөн хугацаанд ямар байр суурь баримталж, юу хийв ээ гэдгээс яриагаа эхлэх үү?

–УИХ болон Засгийн газраас “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэнд, 10 хувийг аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, 30 хувийг хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө босгох, мөн 1072 хувьцааг 1.0 сая төгрөгтэй дүйцүүлэн, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоох зэрэг олон шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэрүүдийн нэг нь арилжаа эхлэх хүртэл иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлийг тогтоосон явдал юм. Өөрөөр хэлбэл, өнөөдөр 1072 хувьцаа энэ нөхцөлдөө хэвээр байна. СЗХ-ноос УИХ, Засгийн газрын шийдвэрүүдэд тухай бүр оролцож, саналаа өгч, бодлогын хүрээнд дэмжиж, байр сууриа тодорхой илэрхийлж байсан.

Хуулиараа СЗХ бол хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага. Иймд дээрх шийдвэрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд шат дараатай ажлуудыг хийж ирсэн. 2015 онд “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшлийн байдлыг баталгаажуулах асуудлыг шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчид гэдэгт төр, 2.4 сая иргэн, 553 аж ахуйн нэгж хамрагдаж байгаа хэрэг шүү дээ. Компанийн ордын ашиглалтын

найман тусгай зөвшөөрлийг 11.196 их наяд төгрөгт дүйцүүлэн үнэлүүлж, хувьцааг баталгаажуулан “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн санхүүгийн тайланд тусгуулсан. Асуудлыг шийдвэрлэхийн тулд бид Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөмж, албан хүсэлт хүргүүлэх зэрэг олон арга хэмжээ авсан. Түүнчлэн “Эрдэнэс–Таван толгой” ХК нь улсын бүртгэлд хувьцаат компанийн хэлбэрээр бүртгэгдсэн боловч Компанийн тухай хуульд заасны дагуу нээлттэй, хаалттай хэлбэрээ тодорхой болгоогүй байсан. СЗХ-ноос компанийн ТУЗ-д шаардлага хүргүүлсний үндсэн дээр өнөөдөр болох хувьцаа эзэмшигчдийн хурлаараа эцэслэн шийдвэрлэхээр болж байна.

–Төрөөс “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн иргэдэд хуваарилсан 1072 хувьцааг хоёрдогч зах зээлд гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг сүүлийн үед нэлээд эрчимжүүлж байна. Үүнд СЗХ ямар үүрэгтэй оролцож байгаа вэ?

–“Эрдэнэс–Таван толгой” ХК эхний алхамд үнэт цаас гаргах ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцэж шийдвэрлэх ёстой. Улмаар үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлт, үнэт цаасны танилцуулга, холбогдох бичиг баримтыг СЗХ-нд ирүүлнэ. Бид уг хүсэлтийг хянаж, хөрөнгийн зах зээлийн нэгж бүтээгдэхүүн болохын хувьд хувьцааг эдийн засгийн болон санхүү, үнэт цаасны орчин нөхцөлтэй нь уялдуулан нягтална. Компани хувьцааныхаа ирээдүйг хэт өөдрөгөөр төсөөлсөн, хийсвэрээр сэтгэсэн, эсвэл улс төржсөн байдлаар төлөвлөж, арилжааг эхлүүлбэл энэ ажил урт наслахгүй шүү дээ. Өнөөдрийн байдлаар бид компани болон арилжаа

эрхлэгч, андеррайтер байгууллагуудтай хамтраад “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн хувьцааг нэг бүр нь 933 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15 тэрбум ширхэг энгийн зарласан хувьцаа, үүний 80 хувь буюу 12 тэрбум ширхэг нь гаргасан хувьцаа байхаар тогтоогоод байна. Мөн “ҮЦТХТ” ХХК дахь “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч иргэдийн тоог эцэслэн гаргаж, бүртгэлийг цэгцэлж байна.

Анх Засгийн газар “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан Монгол улсын иргэнд эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Гэтэл тухайн үед шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй, гадаад улсад оршин сууж байсан, мөн эрхээ хязгаарлуулсан иргэд хувьцаа эзэмших эрхээ баталгаажуулаагүй тохиолдол байсаар байна. Мөн тогтоол гарсан өдрөөс хойш төрсөн хүүхдүүдийн эзэмших эрхийг хэрхэх вэ гэх мэт асуудлууд ч байна. Энэ мэт асуудлуудыг цэгцэлж, “Эрдэнэс–Таван толгой” ХК-ийн хувьцааны эзэмшлийн бүтцийг эцэслэсний үндсэн дээр хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх боломж нөхцөл нь бүрдэнэ.

–Тэгэхээр цэгцлэх шаардлагатай асуудал нэлээд байгаа юм байна. Ер нь 1072 хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгохын тулд СЗХ ямар нөхцөл шаардлага тавьж, хэрхэн хянаж ажиллаж байна вэ?

–“Эрдэнэс–Таван толгой” ХК албан ёсоор олон нийтэд үнэт цаасаа санал болгон /IPO/ гаргаагүй шүү дээ. Тэгэхээр СЗХ-ны үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй байгаа. Олон нийтэд үнэт цаасаа гаргах ажиллагаа нь компанийн удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээс гадна, компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө, зах зээлийн нөхцөл байдал, компанийн засаглал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалдаг, цаг хугацаа их зарцуулагддаг, мэргэжлийн үйл ажиллагаа болдог. Мөн СЗХ-ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгүүлэхийн тулд компани холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байхаас гадна хөрөнгийн үнэлгээ, санхүүгийн тайлан тэнцэл, хууль зүйн дүгнэлт, тухайн компанийн өр төлбөр, алдагдал, хөрөнгийн үнэ цэнэ,

их хэмжээний хэлцэл хийгдсэн байдал, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн байдал, хөрөнгийн биржийн дүгнэлт зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр бүртгэх шийдвэрийг гаргадаг зохицуулалттай. Тиймээс л “Эрдэнэс–Таван толгой” ХК–ийг нээлттэй хэлбэрээр бүртгүүлэх буюу хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг дотоод, гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулахад ихээхэн хэмжээний бэлтгэл ажил шаардлагатай байгаа юм. Бэлтгэл ажлыг олон улсын стандарт, холбогдох хууль, журмын хүрээнд хангахаас тус компанийн цаашид хөрөнгийн зах зээл дээр нэмэлт хувьцаа гаргах замаар шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах ажил амжилттай хэрэгжих эсэх гэх мэт ирээдүйн олон асуудал тодорхойлогддог. Цаг хугацаа ч шаардагдана. Нэмж хэлэхэд, “Эрдэнэс–Таван толгой” ХК дотоодын биржид үнэт цаас гаргасан тохиолдолд танилцуулгад тусгагдсан хөрөнгийг 100 хувь татан төвлөрүүлэх эсэх нь тодорхойгүй байгаа.

–“Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн хувьцаа эзэмшигч иргэдэд ногдол ашиг тараах боллоо гэхэд ямар сувгаар тараах вэ?

–Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн хувьцааны 14.75 хувийг эзэмшиж буй 2.897.277 хувьцаа эзэмшигч байна. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг “ҮЦТХТ” ХХК дээр иргэн бүрийн нэрээр баталгаажуулсан. Иргэн үнэт цаасны компаниар дамжуулан данс нээлгэхэд “Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн хувьцаа уг дансанд шууд шилжиж орно. Иргэд үнэт цаасны хадгаламжийн данстай болсноор зөвхөн “Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн гэлтгүй үнэт цаасны зах дээрх бүхий л хувьцааны арилжаанд оролцох, ногдол ашгаа авах боломжтой.

–Хувьцааны эрх нээгдмэгц Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээрх данс идэвхжинэ. Хувьцаа эзэмшигчдийн өвлөх, бэлэглэх гээд бүхий л эрх нээгдэнэ. Бирж дээр арилжаа эхэлмэгц иргэд олноороо хувьцаагаа зарах, арилжаалах үзэгдэл гарч болзошгүй юм. Энэ тохиолдолд ямар зэрэг болон сөрөг үр дагавар гарч болох вэ?

–Үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс иргэд хоорондын аливаа хэлбэрийн захиран зарцуулалтыг тодорхой хугацаагаар хориглосон байгаа шүү дээ. Холбогдох хууль, журмаар ХК–г хаалттай хэлбэрээр бүртгэх нь



хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг эцэслэн цэгцлэх, баталгаажуулах, тулгамдаад буй зарим асуудлуудыг шийдвэрлэх бололцоог олгодог. Хаалттай ХК–ийн хувьцааг үүсэж болох зарим эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс худалдах, бэлэглэхийг тодорхой хугацаанд хязгаарлах хууль эрх зүйн боломж бий.

“Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн хувьцааны арилжааг эхлүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулснаар олон нийтийн санхүүгийн боловсрол, мэдлэг нимгэн байгаа энэ цаг үед хэд хэдэн эрсдэл гарч болзошгүйг уншигчдад сануулах нь зүйтэй. Хувьцаа эзэмшигчдийн хооронд хувьцаагаа худалдах бололцоог нээх нь хувьцааны ханшийг унагах, хуурамч хэлцэл хийгдэх зэрэг олон сөрөг үр дагаварт хүрч болзошгүй. Мөн бэлэглэлийн гэрээгээр халхавчилсан далд арилжаа үүсэхийг үгүйсгэхгүй. Харин өв залгамжлал харьцангуй эрсдэл багатай, иргэний язгуур эрхийн нэг юм. Иймд өв залгамжлах эрхээ нээхийг хүлээж буй иргэдэд боломжийг олгох ба энэ нь зөвхөн хууль ёсны өв залгамжлагчдад, нарийн журмын дагуу явагддаг үйл ажиллагаа юм. Өв залгамжлалыг бүртгэснээр тухайн иргэд дансаа нээлгэж, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх үед өв залгамжлалын асуудлаар давхар ачаалал үүсгэхгүй байх ач холбогдолтой.

–1072 хувьцаа хоёрдогч зах зээлд гарах нь хувьцааны зах зээлд яаж нөлөөлнө гэж Хороо харж байгаа вэ?

–“Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн төрийн эзэмшлийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалсан тохиолдолд хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн

үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нь мэдээж юм. СЗХ–оос жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах үйл ажиллагаа, мэдээлэл тайлагналын ил тод байдал, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, засаглалд хяналт тавьж ажиллана. Хувьцаа өөрөө компанийн засаглалыг сайжруулах нэгэн том хүчин зүйл юм

–Хувьцааны үнэ ханш унах зэрэг болзошгүй эрсдэл, сөрөг үр дагавараас хэрхэн сэргийлэх вэ? Үүнд хяналт тавих ч юм уу, ямар нэгэн хязгаарлалт тогтоох боломж бий юу?

–“Эрдэнэс–Таван толгой” ХК–ийн хувьцааны арилжаа эхлэхэд нийлүүлэлт нь эрэлтээсээ давж гарах магадлал байхыг үгүйсгэхгүй. Зах зээлийн зарчмаар хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөгөөс унах эрсдэл үүсэж мэднэ. Иймд нийлүүлэлтийг зохицуулах зорилгоор хувьцаа эзэмшигч иргэд хувьцаагаа хэсэгчлэн буюу 100–200 ширхэгээр арилжих, мөн шат дараалан арилжих бодлогыг хэрэгжүүлж болох юм. Гэхдээ энэ нь хувьцаа эзэмшигчид болон хувьцааны үнэд эерэгээр нөлөөлж чадах эсэх нь тодорхой бус юм.

Энэ мэт эрсдэлээс урьдчилан сэргийлж юуны өмнө, компаниар 2019 оноос эхлэн ногдол ашиг хуваарилуулах стратегийг баримталж байна. Өөрөөр хэлбэл, хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж, хувьцаагаа зарахгүй байж гэмээн жил бүр ноогдол ашиг хүртэнэ гэсэн ойлголтыг иргэдэд өгөх замаар хувьцааны нийлүүлэлтийг тодорхой хэмжээнд хязгаарлаж болох юм. Нөгөө талаас гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах чиглэлээр ажиллах, томоохон санхүүгийн төвүүдэд танилцуулга хийх зэрэг арга хэмжээ авч хувьцааны эрэлтийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Мөн эхний ээлжинд дотоодын бирж дээр хоёрдогч арилжааг эхлүүлэлгүйгээр гадаадын томоохон биржүүдэд төрийн мэдлийн хувьцааг гаргах замаар иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцааны үнийг барих бодлогыг хэрэгжүүлэх нь чухал гэсэн байр суурьтай байна.

**Ярилцсан У.Орхон
 (“Монголын үнэн” сонин)**

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР БАНКНААС БУСАД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

“ИЛТ ХУУЛЬ БУСААР ОЛСОН ХӨРӨНГИЙГ МЭДСЭЭР БАЙЖ ОЛЖ АВСАН, ХУВИРГАСАН, ШИЛЖҮҮЛСЭН, ЭСВЭЛ ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛТАЙ БОЛГОХЫН ТУЛД ЭХ ҮҮСВЭРИЙГ НЬ ХАЛХАВЧИЛСАН, НУУН ДАЛДАЛСАН, ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛСЭН, БОДИТ ШИНЖ ЧАНАР, ХЭЛБЭР, БАЙРШЛЫГ НЬ ӨӨРЧИЛСНИЙГ МӨНГӨ УГААХ ГЭЖ ХЭЛНЭ.”



Иймд гэмт хэрэгтнүүд хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоо мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл, хууль хяналтын байгууллагын анхаарлыг татаж, тэдний хараанд өртөлгүйгээр зарцуулах боломжтой болохын тулд санхүүгийн системд нэвтрүүлж, жинхэнэ эх үүсвэрийг нь нуун дарагдуулж, төөрөгдүүлэх замаар хууль ёсны орлого мэт харагдуулахыг зорино.

Мөнгө угаах гэсэн нэр томъёо бий болоод удаагүй байгаа хэдий ч мөнгө угаах гэмт хэрэг нь шинэ биш ба манай эриний өмнөх 2,000 жилийн өмнө татвараас зайлсхийж өөрийн орлогоо удирдагчдаасаа нуун өөр газарт шилжүүлж, өөрийн улсаас гадагш хөрөнгө оруулж, эсвэл газар дор булдаг байсан Хятад улсын наймаачдаас үүсэлтэй гэж үздэг. Зуу зуун жил өнгөрч хавала, хунди нараар мөнгө дамжуулдаг байсан үеэс криптовалютаар дамжуулан мөнгө угаадаг болсон цаг үе ирсэн

ба мөнгө угаах арга хэлбэрүүд цаг хугацааг дагаад боловсронгуй болсоор ирсэн. Мөнгө угаах гэсэн нэр томъёог 1920–оод оны эхэнд АНУ–ын мафийн толгойлогч Аль Капоне хууль бус үйлдлээсээ олсон хөрөнгөө өөрийн угаалгын газраас олсон орлого мэтээр тайлагнадаг байснаас эхлэн бий болсон гэж ярьдаг хэдий ч АНУ–ын Банкны нууцлалын тухай хуулийг 1970 онд баталснаас хойш энэхүү ойлголт албан ёсоор бий болсон гэж үздэг.

Монгол Улсад харьцангуй хожуу буюу 2006 оны 7 дугаар сарын 8–ны өдөр Улсын Их Хурлаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг батлан мөрдүүлснээр уг гэмт хэрэгтэй тэмцэх эхлэл болсон гэж болно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд санхүүгийн байгууллагуудын оролцоо хамгийн чухал учир

мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгайлан авч үзэн мэдээлэх үүрэгтэй этгээд гэж хуульд тодорхойлсон байдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд банкнаас бусад санхүүгийн байгууллагууд буюу банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар заасан байдаг.

Иймд СЗХ–ноос хяналт тавих мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийх зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 14–ний өдрийн 339 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”–ыг батлан мөрдүүлж байна.


Уг журмын агуулга нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалтыг хийхдээ мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг үнэлэхдээ олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу эрсдэлийн үнэлгээг үнэлэх асуулга, матриц, аргачлал дээр тулгуурлан эрсдэлд суурилсан хэлбэрээр хийхээр зохицуулснаараа онцлог юм.

ТУС ЖУРМЫГ БАТЛАХ БОЛСОН ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлаас 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 4.1.2–4.1.7–д заасан этгээд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцахаар заасан бөгөөд мөн хуулийн 19.2–т “Энэ хуулийн 19.1–т заасан эрх бүхий байгууллага/ Санхүүгийн зохицуулах хороо/, Санхүүгийн мэдээллийн алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 19.2.1–т “энэ хуулийн 4.1–д заасан этгээдэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих, шалгалтын удирдамж, журам, заавар, зөвлөмж гаргах” гэж тус тус заасны дагуу Хорооны зүгээс “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”–ыг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон.

ПРАКТИК ШААРДЛАГА

2013 оны 5 дугаар сарын 31–ний өдөр Улсын Их Хурлаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хуулийн 4.1.2–4.1.7–д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдэд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцахаар заасан бөгөөд үүнтэй холбоотойгоор Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 3 дугаар сарын 18–ны өдрийн А–156/45 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам”–ыг батлан мөрдүүлсэн боловч уг журам нь 2016 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс мөрдөгдсөн Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлага хангахгүй болсон. Мөн Мөнгө угаах болон



терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд Улсын Их Хурлаас 2018 оны 4 дүгээр сарын 26–ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо хариуцан хуулийн хэрэгжилтийг хангуулах мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам, заавар батлах эрхийг хуульчилсан тул Хорооноос Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулах шаардлага бий болсон.

ЖУРМЫН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журмын зорилго нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2–4.1.7–д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, заавраар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавихыг хэрхэн хэрэгжүүлж байгаад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчмын дагуу зайнаас болон газар дээр нь хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахад энэхүү журмын зорилго оршино.

Журмын төсөл нь 4 бүлэгтэй байна. Төслийн 1 дүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл буюу журмаар зохицуулагдах харилцаа хяналт шалгалтын төрөл, хэлбэр, төслийн 2 дугаар бүлэгт зайнаас хяналт тавихтай холбоотой харилцааг, төслийн 3 дугаар бүлэгт газар дээрх хяналт шалгалт хийхтэй холбоотой

харилцааг, төслийн 4 дүгээр бүлэгт хариуцлагын талаарх зохицуулалтыг тус тус тусгасан болно.

АЧ ХОЛБОГДОЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд Санхүүгийн зохицуулах хорооноос хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зохицуулалтын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтын ажиллагааг илүү боловсронгуй болгосноор мэдээлэх үүрэгтэй этгээдэд үүсч болзошгүй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зохицуулалтын орчныг сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ.

Мөн түүнчлэн манай улс APG(Ази, Номхон далайн бүсийн бүлэг)–ийн гишүүн орны хувьд FATF буюу Санхүүгийн арга хэмжээ авах байгууллагын 40 зөвлөмжийг мөрдлөг болгон, нийцүүлэх үүрэгтэйн хувьд тус зөвлөмжид дурдсан хууль, эрх зүйн орчныг сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд улмаар Монгол Улсыг Олон Улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллагын “саарал жагсаалт”–д оруулах эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ



Шинэ технологийн шийдлүүд даатгалын зах зээлд нэвтрэхийн хэрээр урьд өмнө нь байгаагүй их хэмжээний мэдээлэл, дата сан, шинэ системүүд, гарааны бизнесүүд, хэрэглэгчдийн хувийн өвөрмөц онцлогт нийцсэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ шинээр бий болж байна.

Дижитал технологийн дараагийн давалгаа болох “Юмсын интернет” буюу “Internet of Things (IoT)”, хиймэл оюун ухаанд суурилсан платформ зэрэг нь даатгалын байгууллагын мөн чанарыг өөрчилж байна. Эдгээр дижитал трендүүд нь даатгалын компаниудыг уламжлалт хэв маягаасаа давсан, илүү өргөн цар хүрээг хамарсан бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байна.

Зөвхөн түүхэн өгөгдөл ашиглан үнийн тооцоолол, эрсдэлийн үнэлгээг хийдэг байсан бол дижитал технологи нь хэрэглэгч тус бүрээр, бодит цагийн горимоор эрсдэлийг шууд буюу автоматаар үнэлэх боломжийг олгохоос гадна хэрэглэгчдэд гарч болох эрсдэлээс зайлсхийхэд дэмжлэг үзүүлж байна. Гэвч даатгагчид эдгээр давуу талыг бий болгохын тулд ажиллах хүч болон байгууллагын соёлыг эрс өөрчлөх шаардлагатай тулгарч байгаа юм.

Хэдий дижитал технологиуд нь олон давуу талыг зах зээлд бий болгож байгаа ч сөрөг үр дагаврыг мөн дагуулж байна. 2013 оны Оксфорд Мартины судалгаагаар даатгалын салбарын ажлын байр нь автомат системээр орлуулагдах хамгийн өндөр эрсдэлтэй болох нь харагджээ. Түүнчлэн салбарт шинэ үүрэг

нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, даатгагчид авто төхөөрөмж үйлдвэрлэгчид, технологийн компаниуд зэрэг гуравдагч талтай хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бий болгож буй экосистем нь үүний нэг жишээ юм. Түүнчлэн одоо байгаа ажил үүрэгт өөрчлөлтүүд гарах төлөвтэй байна.

Хувьсан өөрчлөгдөж буй технологийн эрин үед технологийн чадвар, мэдлэг боловсрол эзэмшсэн ажиллах хүчин нь даатгагчдын хувьд чухал шаардлагатай хүчин зүйл болж байна. Иймд уламжлалт хэв маягаар ажиллаж дадшисан ажилтнууд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд зах зээлд гарч буй өөрчлөлттэй зэрэгцэн өөрсдийгөө хөгжүүлэх хэрэгцээ үүсч байгаас гадна тус чиглэлд мэргэшсэн боловсон хүчинг бэлдэх асуудал гарч ирж байгаа юм.

Морган Стэнли болон Би Си Жи-гийн 2014 онд хийгдсэн “Даатгал ба технологи: Дижитал ертөнц дэх өөрчлөлт, хувьсал” хэмээх судалгаанд даатгалын компаниудын үзүүлж буй үйлчилгээнд хэрэглэгчдийн сэтгэл ханамж маш доогуур байгаа тухай дурджээ. Тус үр дүнгээс үзэхэд салбарт аль хэдийнээ шинэчлэлт өөрчлөлт хийх шаардлага үүссэн нь харагдаж байна. Түүнчлэн технологийн дэвшил нэвтрүүлэлт болон даатгалын үйл ажиллагааны автоматжуулалт нь салбарын өнөөгийн нөөц бололцоо буюу потенциалыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байгаа билээ.

Зах зээлд гарч буй технологийн өөрчлөлт, хувьсгалыг бий болгохын тулд томоохон технологийн компаниуд дижитал соёлыг бий болгох, дараагийн хөгжлийн түвшинд хүрэхийн тулд инновацийн лаб үүсгэн байгуулах, эсвэл технологийн гарааны бизнесийг дэмжих зэрэг хэлбэрээр хувь нэмрээ оруулаад зогсохгүй, тус технологийг авч хэрэглэж буй даатгалын компаниуд эхнээсээ гарч ирж байна. Харин бусад даатгалын компаниудын хувьд инновацийн шинэ шийдлүүдийг нэвтрүүлэхийн тулд технологийн компаниудтай хамтран ажиллаж байна.

Дижитал фирмүүд хөдөлгөөнт төхөөрөмж, нийгмийн сүлжээ болон үүлэн системийг илүү сайн шийдвэр гаргалт хэрэгжүүлэх, үйл ажиллагааг автоматжуулах, хэрэглэгчид ажилчид болон зуучлагчидтай харилцаагаа гүнзгийрүүлэх, үр ашигтай инновацийг хурдацтай хөгжүүлэх зэрэгт ашиглаж байна. Цаашилбал, хамгийн амжилттай яваа дижитал фирмүүдийн хувьд байгууллагын үйл ажиллагааны аль ч түвшинд салбартаа тэргүүлж, ялгарч эхлээд байна. Дижитал технологи нь байгууллагын стратеги, зохион байгууллагын бүтцээс эхлээд өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын байрны соёлд ч нөлөөллөө үзүүлж эхлээд байгаа юм.

Олон улсын даатгалын зах зээлд гарсан технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ болон технологийн дэвшлийн жишээг дор дурдав.

ДОТООД АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УРСГАЛЫГ АВТОМАТЖУУЛАХ

Автоматжуулалт нь өдөр тутмын ажилд зарцуулагдах зардлыг бууруулах боломжтой бөгөөд ажилчдыг өөрийн цагаа илүү үр бүтээлтэй ажил үүрэгт анхаарал хандуулах боломжийг олгоно. Зардал хэмнэсэн нэг жишээ бол Fukoku Mutual Life Insurance-ийн даатгуулагчдад олгох нөхөн төлбөр тооцоолох автоматжуулалтын систем юм. Тус компани нь 34 ажилтныг хиймэл оюун ухааны системээр орлуулсан ба энэ нь бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлж, эхний жилдээ 1.25 сая долларыг хэмнэн, өгөөжөө 2-оос бага жилийн хугацаанд өгнө хэмээн үзэж байгаа аж. Тухайлбал гадаад болон дотоод баримт, албан бичгийн урсгалыг автоматжуулах боломжтой юм. Санхүүгийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мянга мянган файлыг цуглуулж, архивладаг. Энэ нь мэдээлэл хадгалах, боловсруулах, солилцох хамгийн сайн арга биш бөгөөд байгаль орчинд ч сөрөг нөлөөтэй. Хэрэв эдгээр файлууд нь цахим хэлбэрт шилжиж, үүлэн системд хадгалагдвал албан бичиг нь автомат хэлбэрээр хянагдаж, алдаатай мэдээллийг үл зөвшөөрч, улмаар даатгалын ажилчид үнэн зөв мэдээлэлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Архивлагдаж, тоос буртаганд дарагдах мэдээллийг илүү үнэ цэнэтэй болгох үүднээс, зураг болон текст таних алгоритмыг хөгжүүлэх нь өөр нэг гарцыг нээж өгч байна.

НӨХӨН ТӨЛБӨР ТООЦООЛОХ УХААЛАГ МАШИН

AI insurance software нь даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагааны явцад өөр нэгэн өөрчлөлтийг хийжээ. Тухайлбал газар нутагт ган гачиг тохиоход даатгалын хохирлыг үнэлэхтэй холбоотой шаардлагатай мэдээллийг цуглуулахад маш их цаг хугацаа, зардал шаардагдана. Харин AI-ийн хөгжүүлсэн тус төхөөрөмжийн алгоритм нь хиймэл дагуул, эсвэл дронд тусгасан зургийг ашиглан гантай газар нутгийн хэмжээ, учирсан хохирлыг тооцоолох боломжийг олгож байгаа юм. Улмаар энэ нь хүний хүчин зүйлсийг бууруулж, цаг болон зардлыг бууруулна. Түүнчлэн даатгалын нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах процесс нь мэдээлэл цуглуулагч ухаалаг төхөөрөмж

болон гар утасны технологиудыг хослуулах замаар өөрчлөгдөн хөгжиж байна. Тухайлбал State Farm нь хэрэглэгчдэд зориулан Pocket Agent application-ийг нэвтрүүлээд байна. Үйлчлүүлэгч тээврийн хэрэгслийн зургийг илгээснээр нөхөн төлбөрийн нэхэмжлэх процесс нь цаасан баримт бичиг эсвэл нүсэр веб хувилбар ашиглаж, цаг гарздахгүйгээр хийгдэх юм.

НЭХЭМЖЛЭЛ БОЛОН ГЭРЭЭНИЙ УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛТ

Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн менежмент



Нэхэмжлэлийн менежмент нь даатгалын компанийн бизнесийн чухал үйл явц бөгөөд энэ нь нэхэмжлэлийн бүртгэлээс эхэлж, даатгуулагчид төлөх нөхөн олголтоор дуусгавар болдог. Нэхэмжлэлийн менежментийн програм хангамж нь гар ажиллагаа болон хүн хоорондын харилцааны үйл явцыг багасгаж, улмаар нэхэмжлэх шийдвэрлэгдэх явцыг илүү хялбаршуулж, түүнд зарцуулагдах хугацааг богиносгох давуу талыг үүсгэдэг. Түүнчлэн даатгалын компаниудын зүгээс үзэхэд автоматжуулалтаар дамжуулан хөдөлмөрийн зардлыг бууруулах боломжийг бүрдүүлдэг байна. Гэрээний менежментийн програм хангамж нь холбогдох тохиргоо, өөрчлөлтүүдийг хийх, гэрээний нөхцөлийг удирдах зэрэг үйлдэл хийхэд шаардагдах хэрэгслээр хангах үүрэг бүхий нийт системийн дэд хэсэг юм.

SAP, Oracle, Patra Corp, GuideWire, Claim Kit, Inslу зэрэг байгууллагуудын гаргасан програм хангамж нь даатгалын салбар дахь нэхэмжлэл болон гэрээний удирдлагын хэрэгслийн нийтлэг хэрэгцээг хангаж байгаа юм. Гэвч AI, Блокчэйн, IoT зэрэг технологид суурилсан даатгалын технологийн гарааны бизнес эрхлэгчид болон технологийн зөвлөх компаниуд салбарт гарч буй голлох инновацийг бий болгож байна.

ИОТ БОЛОН ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭН ДЭХ МЭДЭЭЛЭЛ БА ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

Суурин болон хөдөлгөөнт төхөөрөмжүүдээр дамжуулан цусны даралт, халуун, судасны цохилт зэрэг хэрэглэгчдийн бие физиологийн нөхцөлийн талаарх мэдээлэл, мөн хэрэглэгчийн өдөр тутмын амьдралын хэв маягийн талаарх мэдээллийг цуглуулж, даатгуулагчийн өвөрмөц онцлог, шинж чанарыг агуулсан өргөн хэмжээний дата баазыг үүсгэх боломжтой юм. Тухайлбал өдрийн алхалтын тоо, шүд угаахад зарцуулах хугацаа гэх мэт. Түүнчлэн Фэйсбүүк, Твиттер

болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өгөгдлүүд тус дата баазыг баяжуулах өөр нэгэн эх үүсвэр болж байна. Энэ нь мэдээлэл цуглуулагч төхөөрөмж эсвэл ямар нэгэн урьдчилан таамаглагч анализ хийгч аппликэйшн ашиглан хэрэглэгчийн эрсдэлийн хандлагыг тодорхойлох замаар хийгддэг бөгөөд бүх өгөгдөл, мэдээлэл нь бодит цагийн горимоор ашиглагдах боломжтой юм.

Веат бол үүнтэй холбоотой өөр нэгэн жишээ юм. Тус компани нь шүдний даатгалын бүтээгдэхүүн санал болгохдоо IoT технологийг ашиглажээ. Ухаалаг шүдний сойз нь хэрэглэгчдийн шүдээ хэрхэн арчилж байгаа өдөр тутмын бичлэгийг хийх ба даатгалын компани шүдний сойзонд тэмдэглэгдсэн датаг ашиглан тухайн үйлчлүүлэгчдэд зориулсан даатгалын төлөвлөгөөг гаргах юм. Веат нь бусад өрсөлдөгч байгууллагуудтай харьцуулахад 25 хувиар доогуур үнийн түвшинг санал болгож байгаа аж.

ТЕЛЕМАТИК ДААТГАЛ

Телематик даатгал нь хар хайрцагтай ижил зарчмаар ажилладаг машины даатгалын шинэлэг бүтээгдэхүүн юм. Телематик хайрцгийг машинд суурилуулах ба тус төхөөрөмжид GPS систем, хөдөлгөөн

мэдрэгч, сим карт болон шинжилгээ хийгч програм хангамж суурилуулагдсан байдаг. Телематик хайрцаг нь хурд, байршил, цаг, автомашины осол, жолоодлого хоорондын зай, эвдрэл болон бусад жолоодлоготой холбоотой мэдээллийн бичлэгийг хийдэг. Уг систем нь цугласан мэдээллийг боловсруулж, гар утасны интернетээр дамжуулан даатгалын компани руу цаашдын шинжилгээнд зориулан мэдээллийг илгээнэ. Түүний дараагаар жолоодлогын шинжилгээний тайлан нь хэрэглэгчийн хувийн мэдээллийн дансруу нэмэгдэнэ.

Жолоочийн жолооны зан үйлдлийн талаар бичлэг хийгдсэнээр даатгалын компаниуд хэрэглэгчдэд тусгайлан зориулсан даатгалын төлөвлөгөөг гаргаж, эрсдэлийн удирдлагаа сайжруулж чадах юм. Тухайлбал компани хариуцлагагүй жолооч нарын хураамжийг нэмэгдүүлж, аюулгүй жолооддог харилцагч нарыг урамшуулж, мөн авто тээврийн хэрэгслийн ослын талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх боломжийг бүрдүүлнэ.

Р2Р ДААТГАЛ

Пийр тү пийр (Р2Р) даатгал нь боломжит технологи дээрээ суурилан хөгжих боломжтой гэдгээрээ хурдацтай нэрд гарч буй хамгийн амжилттай бизнесүүдийн нэг юм. Ижил төстэй эрсдэлээ даатгах зорилготой хэрэглэгчид өөрсдийн хураамжийн орлогоор сан бүрдүүлэх замаар зөвшилцөлд хүрэх бөгөөд тус загвар нь уламжлалт даатгалын дундын зуучлал шаардлагагүй гэдгээрээ онцлог юм. Даатгалын тохиолдол гарах бүрд боломжит шаардлагатай мөнгөн хөрөнгийн дахин санхүүжилт хийгддэг. Ингэснээр хэрэглэгчид зардлаа хамгийн бага байлгаж, нэхэмжлэхтэй холбогдох зөрчлөө бууруулдаг.

БЛОКЧЕЙН БА ДАВХАР ДААТГАЛ

PWC-ийн 2016 онд хийгдсэн “Давхар даатгагчдад зориулсан блокчейн” хэмээх судалгаанд блокчейн технологийн даатгалын салбар дахь хэрэглээ нь дэлхий даяар давхар даатгалын компаниудад 5–10 тэрбум ам.долларын хэмнэлтийг бий болгохоор хүлээгдэж байгаа тухай дурджээ. Давхар даатгалын мөн чанар нь сүлжээний бүтэцтэй ойролцоо бөгөөд төлбөр тооцооны дараа орох финтек дэх хоёр дахь том мөнгөн гүйлгээний

бүртгэлийн сүлжээ /distributed ledger/ юм. Тус технологи нь баталгаажуулах хугацааг богиносгох, алдааг арилгах, нэр хүнд алдах эрсдэлийг бууруулах зэрэг томоохон давуу талуудыг бий болгодог. Блокчейн технологийг ашигласнаар давхар даатгагч компаниуд үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг хүлээн авахын тулд даатгалын компанитай харьцах шаардлагагүй болох юм. Тухайлбал, эрүүл мэндийн эрсдэлийн давхар даатгалын нэг гэрээг хийхэд хэд хэдэн даатгалын тохиолдлыг шалгах шаардлага гардаг. Хэрэв талууд ухаалаг гэрээгээр холбогдвол давхар даатгалын компани нь даатгуулагчийн эрүүл мэндийн мэдээлэл рүү шууд хандах боломжтой болох юм. Түүнчлэн тус технологи нь давхар даатгагчдад үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэг. Бичиг баримт боловсруулах нарийн төвөгтэй байдлын улмаас нэхэмжлэл шийдвэрлэх үе шатуудад алдагдал үүсэх боломжтой байдаг бол блокчейн технологи нь гэрээ тус бүрээр богино хугацаанд, гар ажиллагаагүйгээр хохирлын үнэлгээний түүхийг хөтлөх замаар тус эрсдэлийг шийдвэрлэдэг. Улмаар энэ нь илүү хариуцлага тогтоох, зөрчлийг шийдвэрлэх боломжийг олгодог.

ЧАТБОТ

Жил бүр даатгалын компаниуд эрэлт талын мэдээлэл цуглуулах, түүний тайлагналын стандартыг бий болгох, улмаар хэрэглэгчдийн шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэх зэрэгт маш их цаг хугацааг зарцуулдаг. Чатбот, гар утасны технологиуд болон дуу хоолой таних алгоритм нь эдгээр төвөгтэй үйл ажиллагааг автомат болгон, хялбарчилж өгдөг. Эдгээрээс чатбот нь томоохон хэрэглэгчийн үйлчилгээний төвтэй ижил хэмжээнд үр ашигтай ажиллаж, харилцагчдыг дэмжих болон борлуулалттай холбоотой зардлыг эрс бууруулж байна.

Америк дахь зарим нэг даатгалын компаниуд хэдийн эдгээр технологийг ашиглаж эхлээд байна. Канадын Онтариод байрлах Excalibur Insurance хэмээх байгууллага үйлчлүүлэгчидтэй харьцах автомат AI роботыг ашиглалтад оруулжээ. Тус робот нь 7 хоногт 24 цаг вэб хуудас болон Фэйсбүүкээр дамжуулан идэвхтэй байгаад зогсохгүй систем өөрөө шинэ харилцагчдыг татаж, нэхэмжлэл болон үйлчилгээний хүсэлтийг шийдвэрлэдэг. Үйлчлүүлэгчтэй харилцах

төвийн дуудлагын 70 хувь нь л хариулт авч чаддаг байсан бол тус систем энэхүү асуудлыг шийдвэрлэх нэгэн гарц болж чаджээ. Түүнчлэн ухаалаг систем нь шинэчлэгдсэн мэдээлэл илгээх, агентуудад үүрэг даалгавар өгөх, үйлчлүүлэгчдээ хадгалж үлдэх үүднээс нөхөрсөг мэндчилгээ болон тусгай санал илгээх замаар тэдэнтэй халуун дулаан харилцаа үүсгэх зэрэг үйлдлүүдийг хийдэг байна.

ДААТГАЛЫН АРІ

Хэт өндөр, хатуу зохицуулалт, уламжлалт маягийн бизнес загвар, технологийн хүчин чадал дутмаг байдал нь салбарын инновацийн хөгжлийг удаашруулдаг. Гэтэл бодит байдал дээр хэрэглэгчид уян хатан, инновацлаг зүйлийг хүсч байдаг. IBM-ийн судалгаанд даатгуулагчдын 41 хувь нь даатгалын компаниуд хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад гарч буй өөрчлөлтийг хангах үйлчилгээ үзүүлдэггүй учир өөр байгууллагыг сонгоход хүргэдэг тухай дурдсан байна.

Даатгалын API (Application Programming Interfaces) нь даатгагчдад гуравдагч этгээдтэй мэдээлэл хуваалцах, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангаж өгснөөр дээрх асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус технологи нь компаниудад хэрэглэгчдэдээ илүү сайн, цоо шинэ дижитал бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох, цаашлаад борлуулалтаа нэмэгдүүлж, бизнесийн загвараа хөгжүүлэх боломжийг олгож байгаа юм.

Жишээлбэл, нэгэн даатгалын компани API-ийг ашигласнаар онлайн аяллын агентлагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэн аяллын даатгалын онлайн зах зээлд нэвтрэх боломжтой болжээ. Тус компани booking.com, Travelcity зэрэг онлайн аяллын агентлагуудын вэб хуудсаар дамжуулан аялагчдад даатгалын бүтээгдэхүүнийг шууд худалдах болсон нь тухайн байгууллагын борлуулалтыг огцом өсгөсөн байна.

ДААТГАЛЫН ЗАЛИЛАНГ ИЛРҮҮЛЭХ ПРОГРАМ ХАНГАМЖ

Даатгалын салбарын хувьд залилан нь томоохон асуудлуудын нэг билээ. Америкийн “Даатгалын Залилангийн Эсрэг Эвсэл”-ээс мэдээллэсэнээр АНУ-д жилд хамгийн багадаа



л залилангаас үүдэлтэй 80 тэрбум долларын алдагдал хүлээдэг бөгөөд энэ нь Хойд Америкийн даатгалын компаниудын хувьд нийт нөхөн төлбөрийн зардлын 5–10 хувийг эзэлж байгаа юм. Үүлэн болон үүрэн телефонд суурилсан технологиуд нь даатгалын агентлагуудад давхардсан нэхэмжлэл, хэт өндөр үнэлгээ, хуурамч онош, хуурамч гэр бүл болон хамааралтай этгээд үүсгэх зэрэг эрсдэлээс сэргийлэх хүрээнд бодит цагийн мэдээллээр хангах, мөн даатгалын тоон өгөгдлийн тасралтгүй байдлыг хангах, ажилчдаас үүдэлтэй алдааг бууруулах зэрэгт дэмжлэг үзүүлдэг байна. Тухайлбал, үйлчлүүлэгч өөр өөр огноотой боловч ижил даатгалын тохиолдол дээр хуурамч бичиг баримт бүрдүүлэн нөхөн төлбөр нэхэмжилсэн тохиолдолд систем нэхэмжлэлийн өгөгдлийг мэдээллийн сан дахь өгөгдөлтэй харьцуулан, залилангийн хэргийг илрүүлэх юм. Энэ нь үйл ажиллагааны хурдыг нэмэгдүүлэх, илүү нарийвчлалтай боловсруулалт хийх, мөн талуудын ашиг сонирхлын зөрчлийг арилгах замаар даатгалын үйл ажиллагаатай холбогдох зардлыг бууруулах давуу талтай.

ДААТГАЛЫН ЦАХИМ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

Даатгалын гэрээ байгуулахын тулд даатгалын агентлаг руу биеэр очих, утсаар ярьдаг өдрүүд ард хоцорчээ. Вэб хуудас нь хэрэглэгчдэд зах зээл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл авах боломжийг олгохоос гадна, даатгалын компаниуд тухайн хувь хүний шаардлага хэрэгцээнд тохирсон тусгай төлөвлөгөөг санал болгох болжээ. Insurfy, CoverHood, Friendsurance зэрэг даатгалын бүтээгдэхүүний худалдааны платформууд нь даатгалын бүтээгдэхүүний түгээлтийн сувгийн загварыг шинээр тодорхойлох

болов. Үйлчлүүлэгчид өөрсдийн хүссэн бүтээгдэхүүний талаарх нарийн мэдээлэл авахын зэрэгцээ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд ч мөн хэрэглэгчийн эрэлтэд нийцэх бүтээгдэхүүн санал болгож чадвал олон нийтэд илүү танигдах боломжтой болж байна.

ДҮГНЭЛТ

Даатгалын салбарт шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэгч, хөгжүүлэгч, шинийг эрэлхийлэгч оролцогчид нэн шаардлагатай байгаагаас гадна хурдацтай хөгжиж буй технологийн дэвшлийдтэй зэрэгцэн даатгалын салбарын хувьд ч өнөөгийн уламжлалт бизнесийн загвараас шинэ инновацлаг загвар луу шилжих шаардлагатай байна.

Телематик даатгал нь хэрэглэгчдийн зан байдлыг тодорхойлох, түүнд тохирох эрсдэлийн хамгаалалтыг бий болгох, цаашлаад бизнесийн шинэ загварт хүрэх замыг илүү нээлттэй болгож байгаа бол AI даатгалын шийдэл нь хэрэглэгчийн хувийн онцлогт тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох, робот зөвлөхийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мөн залилан, хууран мэхлэлтийг илрүүлэх үйл ажиллагааг сайжруулах боломжоор хангаж байна. Түүнчлэн даатгал гэлтгүй бүх салбарт тренд болоод байгаа блокчейн технологи нь байгууллагын үйл ажиллагааны засаглалыг сайжруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг нөлөөлөлтэй байгаа бол даатгалын API нь мэдээлэл солилцох үйл явцыг илүү хялбаршуулж, бүтээгдэхүүн хүргэлтийн сувгийг онлайн сувгаар дамжуулан илүү өргөн хүрээг хамруулах, улмаар даатгуулагчид илүү уян хатан бүтээгдэхүүнийг санал болгох боломжоор хангаж байна.

Салбарт гарсан технологи, инновацийн дэвшлийн нөлөөллийг өргөн хүрээнд авч үзвэл шинэ инновацийн дэвшлүүд салбарт нэвтэрснээр зарим зардал өндөртэй үйл ажиллагааг автоматжуулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хүргэлтийн сувгийг хөнгөвчлөх, мөн удирдлагын програм хангамжуудаар дамжуулан илүү үр ашигтай үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үйл ажиллагааны зардлыг хэмнэн, цаашлаад технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэж, салбарт төрөлжилт үүссэнээр ашигт ажиллагаанд эерэг нөлөөллийг бий болгож байна. Түүнчлэн хэрэглэгчийг таньж мэдэх, хуурамч даатгалын тохиолдол үүсгэн залилан, хууран мэхлэлт хийх үйл ажиллагаатай холбоотой алдагдлыг эрс бууруулж байгаа нь салбарын ашигт ажиллагаанд тодорхой нөлөөллийг үзүүлж байгаа юм.


Даатгалын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн талаарх маш олон тооны хүчин зүйлсийн тоон өгөгдөл болон статистик дээр суурилан хийгддэг бизнес юм. Гэвч салбарын хувьд бодит цагийн өгөгдөл бус түүхэн өгөгдөл дээр суурилсан шинжилгээ хийгдсээр байна. Харин дижитал технологи нь асар том хэмжээний бодит цагийн өгөгдлийн урсгалыг бий болгож, үйлчлүүлэгч тус бүрийн хувийн мэдээллийн сан бүрдүүлэх боломжийг бий болгож байна. Улмаар хэрэглэгчийн талаарх хувийн, нарийвчилсан мэдээлэл дээр суурилан яг тухайн хэрэглэгчийн эрсдэлийн аппетитад нийцсэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ, үнэ өртгийг санал болгож байгаа нь илүү хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

“МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ҮНЭЛЭХ ТҮҮВЭР СУДАЛГАА”

Санхүүгийн зохицуулах хороо, Эн Ар Си Си ХХК-тай хамтран 2018 оны 3 дугаар улиралд Монгол улсын санхүүгийн хүртээмж, иргэдийн санхүүгийн үйлчилгээний хэрэглээг судлах зорилгоор түүвэр судалгааг хийж гүйцэтгэсэн ба судалгаанд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 1600 иргэдийг хамруулж, утасны ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч гол үзүүлэлт болох 1000 хүнд ногдох арилжааны банкны дансны тоогоор манай улс өндөр орлоготой орнуудтай харьцуулагдахуйц түвшинд байна. Түүнчлэн иргэдийн санхүүгийн байгууллагуудаас зээл авсан хувь өндөр байна. Харин санхүүгийн байгууллагад хадгаламжтай иргэдийн хувь дэлхийн дунджаас бага байна.


Зураг 1. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж



Эх үүсвэр: Global Findex Data, World Bank


Дэлхийн бусад улс орнуудад эмэгтэйчүүдийн санхүүгийн үйлчилгээнд хамрагдалтын түвшин эрэгтэйчүүдийнхээс бага байх тохиолдол их байдаг бол манай улсын хувьд хүйсийн ялгаа байхгүй буюу эмэгтэйчүүдийн 92.1 хувь, эрэгтэйчүүдийн 91.5 хувь нь арилжааны банкинд идэвхтэй данстай байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн байдал болон орлогын түвшний хувьд хүйсийн ялгаа ажиглагдсан ба эрэгтэй хүмүүсийн орлогын 71 хувийг цалингийн орлого бүрдүүлж байхад эмэгтэй хүмүүсийн орлогын 55 хувь нь цалингийн орлого байна. Мөн эрэгтэйчүүдийн хувьд нийт орлогын 15 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого бол эмэгтэйчүүдийн хувьд 34 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого байна.

Зураг 3. Иргэдийн орлогын эх үүсвэр, хүйсээр




Санхүүгийн үйлчилгээний хүртээмж: Судалгаанд хамрагдсан иргэдийн 95.6 хувь нь арилжааны банкинд өөрийн нэр дээр ядаж нэг данс эзэмшдэг бөгөөд 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг байна. Мөн иргэдийн 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 3.4 хувь нь хадгаламж, зээлийн хоршоогоор үйлчлүүлдэг байна. Эндээс үзвэл Монгол Улсын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг бол 0.3 хувь нь албан бус санхүүгийн үйлчилгээг ашиглаж, үлдсэн 5.2 хувь нь санхүүгийн үйлчилгээний хүрээний гадна байна. Улаанбаатар хотын иргэдийн 93.4 хувь нь идэвхтэй данстай байгаа бол орон нутгийн иргэдийн хувьд уг үзүүлэлт 90.0 хувь байна.

Зураг 2. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, хамрагдалтын хувиар



Санхүүгийн хүртээмж орлогын бүлгээр ялгаатай байна. Хамгийн ядуу бүлгийн 92.6 хувь нь санхүүгийн албан секторын үйлчилгээ авдаг байхад хамгийн өндөр орлоготой бүлгийн 97.8 хувь нь албан сектороор үйлчлүүлдэг байна. Түүнчлэн, хамгийн бага орлоготой бүлгийн 87 хувь нь банкинд идэвхтэй данстай байхад хамгийн өндөр орлоготой бүлгийн 97 хувь нь идэвхтэй данстай байна.


Зураг 4. Санхүүгийн хүртээмж орлогын бүлгээр, хамрагдалтын хувиар



Монгол улсын нэг онцлог нь иргэдийн сууцны төрлөөр хамааран тэдний нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдэд ялгаа ажиглагддаг. Харин санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийн хувьд сууцны төрлөөр ялгаагүй байна. Тухайлбал, гэр хороолол болон орон сууцанд амьдардаг иргэдийн 94 хувь нь санхүүгийн албан секторт хамрагдаж байхад 5.2 хувь нь санхүүгийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй орхигддог байна.


Монгол Улсын хэмжээнд иргэд тогтмол үйлчлүүлдэг банкны салбартаа очихын тулд дунджаар 1350 төгрөг, 16 минутыг зарцуулдаг байна. Энэхүү зардал болон хугацаа нь бүс нутгуудын хувьд ялгаатай байна. Тухайлбал, Хангайн бүсийн иргэд банкны салбарт очихдоо хамгийн их зардал (2073 төгрөг) болон хугацааг (19 минут) зарцуулж буй нь улсын дунджаас 723 төгрөг, 3 минутаар илүү байна. Харин Улаанбаатар хотын иргэд хамгийн бага зардал (964 төгрөг) болон хугацааг (15 минут) банкны салбарт очиход зарцуулдаг бөгөөд энэ нь улсын дунджаас 386 төгрөг, 1 минутаар бага байна.

Зураг 5. Банкны салбарт очиход зарцуулдаг зардал болон хугацаа, бүсээр




Банкны үйлчилгээний хэрэглээ ба орлогын эх үүсвэр: Орлогын эх үүсвэр хадгаламж хийдэг давтамжтай хамааралтай байна. Тухайлбал, цалингийн орлоготой, хуримтлалтай хүмүүсийн 72.3 хувь нь сард ядаж нэг удаа хуримтлал хийдэг бол тэтгэвэр, тэтгэмж авдаг хуримтлалтай хүмүүсийн 50 гаруй хувь нь хуримтлал хийдэг байна. Банкны үйлчилгээ авдаг давтамжийг мөн орлогын эх үүсвэрээр нь харвал цалингийн орлоготой хүмүүсийн 91.2 хувь нь сард нэгээс олон удаа банкны үйлчилгээ авч байхад, тэтгэмж болон тэтгэвэр авдаг хүмүүсийн 72–76 хувь нь сард нэгээс олон удаа банкны үйлчилгээ авдаг байна. Эндээс үзэхэд цалингийн орлоготой хүмүүсийн банкаар үйлчлүүлэх болон хадгаламж хийх давтамж тэтгэвэр, тэтгэмж авдаг хүмүүсийнхээс илүү өндөр байна.

Зураг 6. Хадгаламж хийх давтамж орлогын эх үүсвэрээр



Орлогын эх үүсвэр сууцны нөхцөлөөр ялгаатай байна. Гэр эсвэл хашаа байшинтай иргэдийн 29.3 хувь нь тэтгэвэр тэтгэмж авч байхад орон сууцанд амьдардаг иргэдийн 20.8 хувь нь тэтгэвэр тэтгэмж авч байна. Түүнчлэн орон сууцанд амьдардаг иргэдийн 53.2 хувь нь байнгын ажлын цалинтай байхад гэр, хашаа байшинд амьдардаг иргэдийн 39.7 хувь нь байнгын ажлын цалинтай байна.


Зураг 7. Орлогын эх үүсвэр ба сууцны нөхцөл



Монгол Улсын хэмжээнд нийт иргэдийн 90 гаруй хувь нь банкаар үйлчлүүлдэг бөгөөд иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжид сууцны төрөл, орлогын түвшин зэрэг нөлөөгүй байсан бол банкны үйлчилгээ авах давтамж нь эдгээр үзүүлэлтээс хамааран ялгаатай байна. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 52.5 хувь нь өдөр бүр болон долоо хоног тутамд банкны үйлчилгээ авдаг бол гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд энэ нь 17.5 пунктээр бага байна. Харин хотын иргэдийн 46.2 хувь нь долоо хоног тутамд банкаар үйлчлүүлдэг байхад уг үзүүлэлт орон нутгийн иргэдийн хувьд 39.2 хувь байна.

Хадгаламж болон эзэлийн үйлчилгээний хэрэглээ: Сүүлийн 12 сарын хугацаанд нийт хэрэглэгчдийн 30.3 хувь хуримтлалдаа мөнгө хийсэн бөгөөд дийлэнх (94.8 хувь) нь банкинд хадгалдаг гэжээ. Харин 2.3 хувь нь хадгаламж эзэлийн хоршоо, бичил санхүүгийн байгууллага болон нөхөрлөлд хуримтлалаа байршуулсан байна. Мөн 1.7 хувь нь албан бус санхүүгийн хэрэгсэл буюу гэртээ, найз нөхөд эсвэл гэр бүлийн гишүүддээ өгч хадгалуулжээ. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн эсэх нь хэрэглэгчийн бүлгээр харилцан адилгүй байна. Тухайлбал, боловсрол өндөртэй, орон сууцанд амьдардаг, ажил эрхэлдэг, 35–аас доош настай, хотод амьдардаг, өндөр орлоготой, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг хүмүүс хуримтлалдаа мөнгө хийсэн гэж хариулах нь илүү их байна. Харин хүйс, гэрлэсэн байдал болон газар эзэмшдэг нь иргэдийн хуримтлал хийсэн эсэхэд нөлөөгүй байна.

Зураг 8. Өнгөрсөн 12 сарын хугацаанд хуримтлал хийсэн хэрэглэгчид, бүлгээр



Хэрэглэгч хуримтлалдаа мөнгө хийх магадлалд нөлөөлж буй хүчин зүйлсийг логит загвараар үнэлж, шинжилсэн. Ингэхэд орлого (логарифм) болон боловсролд зарцуулсан жил өсөх тусам тухайн хэрэглэгчийн хуримтлалдаа мөнгө хийх магадлал өсөж байгаа бөгөөд энэхүү хамаарал нь статистикийн хувьд найдвартай байна. Мөн баруун бүсэд амьдардаг хэрэглэгч бусад бүсүүдэд амьдардаг иргэдтэй харьцуулахад хадгаламж хийх магадлал өндөр байна. Харин хадгаламж хийх магадлалд хүйс, нас, гэрлэлтийн байдал, болон ажил эрхлэлт нөлөөгүй байна. Хэрэглэгчид гэнэтийн зарлага гарвал (30.8

хувь) эсвэл өдөр тутмын зарлагадаа (13.8 хувь) хэрэглэх гэж хадгалахаас гадна орон сууц, байшин, газар гэх мэт үл хөдлөх хөрөнгө авах зорилгоор (11.4 хувь) хуримтлал хийдэг гэжээ. Үл хөдлөх хөрөнгө авах, өндөр настай үедээ хэрэглэх болон бизнесийн зорилгоор хадгаламж хийж байгаа хэрэглэгчдийг урт хугацааны зорилготой хуримтлал хийдэг гэж үзвэл эдгээр нь нийт хэрэглэгчдийн дөрөвний нэг орчмыг эзэлж байна. Хотод амьдардаг иргэд байр, байшин, газар авах зорилгоор, харин орон нутагт амьдардаг иргэд өдөр тутмын зарлагадаа хэрэглэх зорилгоор гэж хариулах нь эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад арай илүү байна. Бизнесийн зорилгоор

хадгалах нь орлого багатай хэрэглэгчдийн дунд арай бага байна. Өндөр боловсролтой хэрэглэгчид гэнэтийн зарлагадаа хэрэглэх зорилгоор, харин доогуур боловсролтой хэрэглэгчид өдөр тутмын хэрэгцээндээ зориулж хадгалдаг гэсэн хариултыг эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад илүү их өгчээ.

Судалгааны үр дүнгээс харахад хэрэглэгчид хуримтлал хийхдээ урт хугацааны зорилготой гэхээсээ илүү тодорхой бус байдал, эрсдэлээс болгоомжлох болон өдөр тутмын хэрэглээгээ тогтвортой байлгах зорилгоор хадгалах нь давамгайлж байна.


Зураг 9. Хуримтлал хийсэн шалтгаан




Нийт хэрэглэгчдийн 35.4 хувь нь сүүлийн 6 сард зээл авсан бөгөөд нийт иргэдийн 23.1 хувь нь арилжааны банкнаас, 7.9 хувь нь ломбарднаас, 6.5 хувь нь ББСБ-аас, 4.9 хувь нь хувь хүнээс зээл авчээ.

Зээл авсан иргэдийг зээл олгосон байгууллагаар нь харвал арилжааны банк 65.4 хувь, ломбард 22.3 хувь, хувь хүн 13.8 хувь, ББСБ 18.3 хувийг эзэлж байна. Иргэдийн 36.1 хувь нь албан бус сектор буюу ломбард, хувь хүнээс зээл авчээ. Зээл авсан иргэдийн 81.7 хувь нь нэг санхүүгийн байгууллагаас зээл авсан бол үлдсэн 18.3 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд хоёр болон түүнээс дээш байгууллагаас зээл авсан байна. Ажил эрхэлдэг, өндөр орлоготой, 35-аас дээш настай, өндөр боловсролтой, гэрлэсэн, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг иргэдийн зээл авсан байдал нь эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад эрс их буюу 5.3–14.7 пунктээр их байна. Харин хэрэглэгчийн хүйс, байршил, газар эзэмшдэг эсэх, болон орон сууцны төрлөөр зээл авсан байдал бараг ялгаагүй байна. Хэрэглэгчдийн зээл авсан байдлыг бүс нутгаар харахад төвийн бүсийн иргэд хамгийн их (39.6 хувь) зээл авсан гэж хариулсан бөгөөд түүний дараа баруун бүс орж байна. Харин хангайн бүсийн иргэд “зээл авсан” гэж хамгийн бага хариулжээ.

Зураг 10. Иргэдийн зээл авсан байдал



Зураг 11. Зээл авсан байдал, бүлгээр



Мобайл болон интернет банкны хэрэглээ: Мобайл болон интернет банкны үйлчилгээ нь хамгийн өргөн хэрэглэгддэг санхүүгийн үйлчилгээнүүд боловч банкны үйлчилгээнээс ялгаатай нь байршил, сууцны төрөл, хүйс, орлого болон ажил эрхлэлтийн байдлаас хамааран эрс ялгаатай байна.


Нийт иргэдийн 49.1 хувь нь мобайл банкны үйлчилгээ, 27 хувь нь интернет банкны үйлчилгээ авдаг бөгөөд үүн дотроо 19.8 хувь нь мобайл болон интернет аль алиныг нь ашигладаг, 29.3 хувь нь зөвхөн мобайл банк, 7.2 хувь нь зөвхөн интернет банк, 43.7 хувь нь алиныг нь ч ашигладаггүй байна. Улаанбаатар хотын иргэдийн 24.6 хувь нь мобайл болон интернет банк аль алиныг нь хэрэглэдэг байхад Баруун бүсийн иргэдийн ердөө 10.7 хувь нь аль алиныг нь хэрэглэдэг байна. Мобайл болон интернет банкны хэрэглээгээр Улаанбаатар хотын дараа Төвийн бүс орж байна.

Иргэдийн өөрсдийн мэдээлсэн сарын орлогын мэдээнд үндэслэн орлогын таван бүлгээр мобайл, интернет банкны хэрэглээг ангилан харахад, хамгийн бага орлоготой иргэдийн тал нь мобайл болон интернет алиныг нь ч хэрэглэдэггүй бол хамгийн өндөр орлоготой иргэдийн ердөө 20 хувь нь алиныг нь ч хэрэглэдэггүй байна. Гэтэл хамгийн өндөр орлоготой иргэдийн 37.7 хувь нь аль алиныг нь хэрэглэдэг байхад хамгийн бага орлоготой бүлгийн 15.7 хувь нь мобайл, интернет банк хоёуланг нь хэрэглэдэг. Мобайл болон интернет банкны хэрэглээ хүйсээр тийм ч их ялгаатай биш байна.

Даатгалын үйлчилгээний хэрэглээ: Хэрэглэгчдийн 70 хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаггүй бөгөөд тэдний 40 хувь нь даатгалын талаар мэдэхгүй учраас, 26 хувь нь хэрэгцээ, шаардлага байхгүй учраас даатгалд хамрагдаагүй гэж хариулжээ. Даатгалын талаар мэдэхгүй учраас даатгалд хамрагдаагүй иргэд (28 хувь) болон асуултад шууд мэдэхгүй (9.5 хувь) гэж хариулсан иргэдийг нэгтгэвэл, нийт хэрэглэгчдийн 37.5 хувь нь даатгалын талаар огт мэддэггүй гэж үзэж болохоор байна.

Сайн дурын даатгалд хамрагдалт 18.9 хувьтай байгаа бол уг даатгалд хамрагдсан эсэхээ мэдэхгүй иргэд 2 орчим хувь байна. Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн боловсрол, орлого, хөрөнгө эзэмшдэг эсэх, зээл авсан эсэх, хуримтлал хийдэг эсэх болон сууцны нөхцөл зэргээс хамааран харилцан адилгүй байна. Өндөр орлоготой, дээгүүр боловсролтой, сууцанд амьдардаг, зээл авсан, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг, хуримтлал хийдэг, ажил эрхэлдэг иргэдийн хувьд сайн дурын даатгалд хамрагдалт сайн байна. Ялангуяа өнгөрсөн 12 сарын хугацаанд хуримтлал хийсэн иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт хамгийн өндөр буюу 29.3 хувь байна. Харин насны бүлэг, хот хөдөөгөөр сайн дурын даатгалд хамрагдалт бараг ялгаагүй байна.

Зураг 12. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх, бүлгээр



Дүгнэлт: Санхүүгийн хүртээмжийн үндсэн үзүүлэлтээрээ Монгол Улс ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тухайлбал, банкинд данстай иргэдийн эзлэх хувь гэдэг үзүүлэлтээр өндөр хөгжилтэй орнуудын түвшинд байна. Монгол Улсын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг байна. Тухайлбал, иргэдийн 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг бөгөөд 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг. Судалгаанд оролцогсдын 5.2 хувь нь санхүүгийн секторын гадна буюу санхүүгийн үйлчилгээ хүртэхгүй байна. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж бүсээр бага зэрэг ялгаатай байна. Хангай болон төвийн бүсэд санхүүгийн үйлчилгээний хүртээмж бусад орон нутгаас харьцангуй бага байна. Иргэдийн санхүүгийн хүртээмж хүйс болон сууцны төрлөөр ялгаагүй байна. Харин ажил хийдэггүй иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж ажилтай иргэдээс харьцангуй бага байна.

2017 оны байдлаар дэлхийн хэмжээнд нийт насанд хүрсэн иргэдийн 31 хувь нь банкинд дансгүй байна. Манай улсын хувьд энэ үзүүлэлт эрс бага буюу нийт иргэдийн ердөө 4.5 хувь нь банкинд дансгүй байна. Банкнд дансгүй гэж өөрөө мэдээлсэн болон данстай хэдий ч түүнийгээ огт ашиглахгүй байгаа хүмүүсийг энд оруулж тооцсон. Гол төлөв ажилгүй, 25-аас дээш настай, орлого бага, гэр хорооллын иргэд дансгүй байх нь олон байна. Тухайлбал, дансгүй иргэдийн 36 хувь нь хамгийн бага орлоготой бүлгийн иргэд байхад 7 хувь нь хамгийн өндөр орлоготой бүлгийн иргэд байна. Мөн түүнчлэн, дансгүй иргэдийн 63.8 хувь нь эдийн засгийн идэвхтэй иргэд, 36.2 хувь нь идэвхгүй иргэд байна. Данс эзэмшихгүй шалтгаанууд дунд хамгийн өндөр хувь эзэлж буй нь дундаа данстай байх нь зардал багатай (20 хувь) гэснээс үзвэл эдгээр иргэдийн 20 хувь нь данс огт хэрэглэдэггүй биш байгаа юм.

Иргэдийн 44 хувь нь цалингаа авахын тулд, 35 хувь нь мөнгөө найдвартай газар байлгах үүднээс, 24 хувь нь төлбөр авахын тулд мөн 24 хувь нь халамж тэтгэмжийн мөнгө хүлээн авахын тулд данстай болсон гэжээ. Нийт данстай иргэдийн 32 хувь нь 2010 оноос өмнө нээлгэсэн, харин 36 хувь нь дансаа 2010–2018 оны хооронд нээлгэжээ. Хамгийн их данс нээлгэсэн он 2008 он байна. Идэвхтэй

данс ашиглаж буй иргэдийн 65.7 хувь нь нэгээс олон данстай байна.

Ихэнх хэрэглэгчид мөнгөө банкинд хадгалах нь аюулгүй гэж үзэж байна. Хэрэглэгчдийн 30.3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн бөгөөд тэдний 95 орчим хувь нь банкинд хадгалсан гэжээ. Хэрэглэгчдийн ихэнх нь хуримтлалыг урт хугацааны зорилготой хийдэггүй, харин гэнэтийн зарлагадаа хэрэглэх болон өдөр тутмын хэрэглээгээ тогтвортой байлгах зорилготой хийдэг байна. Хадгаламж хийдэг хэрэглэгчдийн гуравны хоёр нь сард нэг буюу түүнээс олон удаа хуримтлалдаа мөнгө хийдэг гэжээ. Өөрөөр хэлбэл, хадгаламжтай иргэд хуримтлалаа давтамж ихтэй хийдэг байна. Нийт хэрэглэгчдийн 35.4 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд санхүүгийн албан болон албан бус байгууллагуудаас зээл авсан бөгөөд хамгийн их үйлчлүүлсэн байгууллага нь арилжааны банк байна. Үүний дараагаар ломбард (18 хувь), ББСБ орж байна. Албан бус санхүүгийн үйлчилгээ буюу ломбард, хувь хүнээс авч байгаа зээл нэлээд их хувийг (30 орчим хувь) эзэлж байна. Хамгийн ядуу бүлгийн зээлд хамрагдалт хамгийн бага байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад иргэдийн хадгаламжийн зах зээлд арилжааны банк илт давамгайлж байна. Үүнтэй харьцуулахад иргэдийн зээлийн зах зээлд арилжааны банк харьцангуй бага хувь (53 хувь) эзэлж байна. Хэрэглэгчид зээл авахдаа бусад санхүүгийн байгууллагаар нэлээд үйлчлүүлдэг ажээ. Тухайлбал ББСБ-аас гадна, албан бус сектор буюу ломбард, хувь хүнээс зээл авдаг байна.

Хэрэглэгчдийн 70 хувь нь сайн дурын даатгалд хамрагддаггүй бол 20 орчим хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг гэжээ. Бүлгээр харахад сүүлийн нэг жилийн хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт хамгийн өндөр байна. Хамгийн хэрэгцээ шаардлагатай даатгалаар эрүүл мэндийн даатгал, түүний дараа гэнэтийн осол, эмчилгээний даатгал болон тэтгэврийн даатгал орж байна. Сайн дурын даатгалд хамрагддаггүй шалтгаануудыг даатгалын талаар мэдэхгүй учраас гэсэн хариулт тэргүүлж байгаа бөгөөд дараагийн гол шалтгаан нь хэрэгцээ шаардлага байхгүй гэсэн шалтгаан байна.



“ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ФОРУМ” (MEFIN)

Бага, дунд орлоготой иргэд хөдөлмөрийн чадвараа алдах, эд хөрөнгөө алдах зэрэг санхүүгийн эрсдэлд эмзэг, өртөмтгий байдаг. Сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг нь дээрх эрсдэлийн түвшинг нэмэгдүүлсээр байна. Даатгалын нөхөн төлбөр нь эдгээр эрсдэлийн эсрэг үр дүнтэй хамгаалалт болж чадах ба төрийн болон хувийн байгууллагууд бага, дунд орлоготой иргэдийг ч мөн даатгалд хамруулах боломжтой гэдэгт итгэх итгэл нэмэгдэж, бичил даатгал нь үр дүнтэй шийдэл болсоор байна. Сүүлийн жилүүдэд Азийн даатгалын зах зээл эрчимтэй өсч байгаа боловч тухайн бүс нутгийн зохицуулах байгууллагууд бага, дунд орлоготой иргэдэд зориулсан даатгалд тохирсон зохицуулалтын орчинг бий болгох тал дээр туршлага, мэдлэг дутмаг байна. Зохистой зохицуулалтын тогтолцоо, хяналтын арга замыг хөгжүүлэн, хэрэгжүүлэх нь энэ зах зээлийг тогтвортой хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Зорилго: Бүс нутгийн хүртээмжтэй даатгалын зах зээлийг дэмжих зохицуулалтын тогтолцоо, үр дүнтэй хяналтын арга замыг хэрэгжүүлэх.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

RFPI Asia II хөтөлбөрийн эхний үе шат нь Азийн бага, дунд орлоготой иргэдэд зориулсан даатгалын зохицуулалтын тогтолцоог сайжруулах зорилготойгоор амжилттай хэрэгжсэн. Хөтөлбөрийн хоёр дахь үе шатанд дээрх зорилгыг үргэлжлүүлэхийн сацуу цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан өсөн нэмэгдэж байгаа эрсдэлийг бичил даатгалын тусламжтайгаар даван туулах асуудалд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Тус хөтөлбөр нь даатгалын зохицуулах байгууллагуудын сүлжээ болох “Хүртээмжтэй даатгалын туршлага солилцох форум”-ыг (Mutual Exchange Forum on Inclusive Insurance MEFIN) байгуулан ажиллаж байна. Тухайн форум нь гишүүдийнхээ дунд мэдлэг, туршлага солилцохыг дэмжин ажилладаг. Анх 2013 онд Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) болон Азийн Хөгжлийн Банкны тусламжтайгаар байгуулагдаж байсан “Хүртээмжтэй даатгалын туршлага солилцох форум” нь бүс нутгийн ядуурлыг бууруулах чиглэлд хүртээмжтэй даатгалыг дэмжих стратегитай ажиллаж буй Азийн улс орны зохицуулах байгууллагуудыг нэг дор хуран цуглуулж, хамтдаа хэлэлцэх боломж олгодог юм.

RFPI Asia II хөтөлбөр нь зохицуулах байгууллага болон даатгалын компаниудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих, хүртээмжтэй даатгалын чиглэлээр тухайн улсад хэрэгжүүлэх шаардлагатай ажил

үүргийг хэлэлцэх, нэгдсэн ойлголттой болгох зорилгоор төр, хувийн хэвшлийн яриа хэлэлцээрийг тогтмол зохион байгуулдаг. Энэхүү яриа хэлэлцээрийн үед “Хүртээмжтэй даатгалын туршлага солилцох форум”-ын гишүүн улс орны төлөөлөгчид шинэ орчин үеийн бизнесийн загвар болон бодлого, зохицуулалтын талаарх өөрсдийн туршлагыг солилцдог.

Тус хөтөлбөр нь мөн олон улсын хяналт, зохицуулалтын стандартын удирдамжийн дагуу хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн болон үр ашигтай борлуулалтын сувгийг хөгжүүлэх чиглэлд дэмжин ажилладаг юм.

“Хүртээмжтэй даатгалын туршлага солилцох форум”-ын Бүс Нутгийн Удирдах Хороо (БНУХ)-ны гишүүд болохын хувьд Индонез, Непал, Монгол, Пакистан, Филиппин, Шриланка, Вьетнам улсын зохицуулах байгууллагууд хөтөлбөрийн хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж байна. БНУХ нь форумын үндсэн дөрвөн ажлын хэсгүүд болох бодлого, зохицуулалтын ажлын хэсэг, бизнес загварын ажлын хэсэг, мэдлэгийн удирдлагын ажлын хэсэг, чадавх бүрдүүлэлтийн ажлын хэсэгт санал, зөвлөгөө өгч ажилладаг. Зохицуулах байгууллагуудын болон даатгалын компаниудын төлөөлөл ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтдаг. Тус хөтөлбөр нь MEFIN-ий нарийн бичгээр ажилладаг ба БНУХ болон ажлын хэсгүүдэд зөвлөгөө, дэмжлэг өгдөг.

ТӨСЛИЙН ҮР ДҮН

MEFIN-ий гишүүд тогтмол хуралдаж, дөрвөн ажлын хэсгээрээ дамжуулан жил бүр гүйцэтгэх ажлаа төлөвлөн хэрэгжүүлдэг.

MEFIN-ий гишүүд болох даатгалын зохицуулах байгууллага болон даатгалын компаниуд жил бүр 2 удаа зохион байгуулагддаг төр, хувийн хэвшлийн хэлэлцээрээр дамжуулан хоорондоо мэдлэг, туршлагаа тогтмол солилцдог. 2016 оны 7-р сард зохион байгуулагдсан төр, хувийн хэвшлийн хэлэлцээрийн дараа Индонез болон Непал улсууд Филиппинээс суралцсан туршлагаа ажил хэрэг болгож эхэлсэн. 2017 оны 3-р сард Вьетнам улсад зохион байгуулагдсан хоёр дахь удаагийн төр, хувийн хэвшлийн хэлэлцээрийн үед Бичил даатгал сэдэвт сургалт, Ази Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй улсуудын бичил даатгалыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцсэн юм. Гурав дахь удаагийн хэлэлцээр 2017 оны 9-р сард Монгол улсад Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хүртээмжтэй даатгал сэдэвтэйгээр, дөрөв дэх удаагийн хэлэлцээр 2018 оны 1-р сард Филиппин улсад Хүртээмжтэй даатгал ба Цахимжуулалт сэдэвтэйгээр, тав дахь удаагийн хэлэлцээр Шриланка улсад Insurtech болон хөдөө аж ахуй, цаг уурын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал сэдэвтэйгээр тус тус амжилттай зохион байгуулагдсан.

Зохицуулах байгууллагууд болон даатгалын компаниуд тус хөтөлбөрийн 7 хоног тутмын видео уулзалт, зөвлөгөө болон бусад мэргэжлийн дэмжлэгтэйгээр тавьсан зорилго, зорилтоо хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүртээмжтэй даатгалын бодлого, зохицуулалт болон бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлаар хөтөлбөрийн багийнхан мэргэжлийн болоод тухайн улс орны онцлог тохирсон зөвлөгөө өгч ажилладаг. Одоогийн байдлаар 18 шинэ бизнесийн загварууд MEFIN-ий цахим хуудаст тавигдаж, олны хүртээл болсон. Эдгээр бизнес загваруудыг мөн төр, хувийн хэвшлийн хэлэлцээрийн үеэр бусдадаа хуваалцан, өөрийн улс орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх боломжийн талаар хэлэлцдэг. Бодлого, зохицуулалтын олон төрлийн арга хэрэгслүүдийг (жишээлбэл Бодлого, зохицуулалтын үнэлгээ, гамшгийн даатгалын гарын авлага) боловсруулан, MEFIN-ий гишүүн улсуудад ашиглаж байна.

ӨРГӨН ДУРАН

Өвлийн олимп, хөл бөмбөгийн ДАШТ-ний хэд хэдэн тоглолтыг хүлээн авсан Сочи хотноо энэ оны 9 дүгээр сард санхүүгийн салбарын хамгийн нүсэр том цугларалт гэж болох Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН, Alliance for Financial Inclusion, AFI)-ийн Дэлхийн бодлогын чуулган (Global Policy Forum) Олимпын дүүргийн Хэвлэл, мэдээллийн төвд таван өдрийн турш хурал чуулсан юм.

Хамгийн нүсэр гэж тодотгосны учир нь СХН-ийн 90 гаруй улсын 100 гаруй гишүүн байгууллагын зэрэгцээ Дэлхийн банк, Германы хамтын ажиллагааны агентлаг зэрэг олон улсын байгууллагууд Дэлхийн бодлогын чуулганд оролцлоо. Нийгэмлэг болон чуулганы 10 жилийн ой тохиосон нь энэ жилийн онцлог байсан төдийгүй оролцогчид санхүүгийн хүртээмжийн олон талт асуудлуудад ихээхэн ач холбогдол өгч, дижитал санхүү, финтекийн шийдлүүд, тэдгээрийн зохицуулалт, хяналтын технологийг эрчимтэй эрэлхийлж байгаа нь үйл ажиллагааг улам нөлөөтэй болгож байсан юм.



СЗХ 2009 онд тус нийгэмлэгт гишүүнээр элссэн бөгөөд 2016 оноос хойш Хорооны төлөөлөл нийгэмлэгийн бүх зургаан ажлын хэсэгт ажиллаж байна. Өнгөрсөн жилийн чуулганаас СЗХ-ны дарга, доктор С.Даваасүрэн тус нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн гишүүнээр сонгогдсон нь санхүүгийн хүртээмжийн асуудлаарх аливаа үйл ажиллагаанд оролцох манай улсын

оролцоо, байр суурийг нэмэгдүүлэх урьдач нөхцөл болсон юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс нийгэмлэгт бодлого боловсруулах, удирдах болон бусад бүх түвшинд идэвхтэй байр суурь баримталж, шаргуу ажиллах гарцаагүй шаардлагатай тулгарсан хэрэг юм.

Үндсэндээ хоёр жилийн өмнөөс эхэлсэн бэлтгэл ажил, цөөн бус удаагийн уулзалт, яриа хэлэлцээ, хэдэн арван төсөл, ноорог бичиг бужигнуулсны эцэст СХН-т Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилгын зөвлөл байгуулагдлаа. Захирлуудын зөвлөлд буюу бодлого боловсруулагч, удирдагч нарын түвшинд энэ санаачилгаа зүтгүүлж, хамгаалан дэмжүүлж, авч гарсан хүмүүс нь доктор С.Даваасүрэн (Монгол), Эльвира Набиулинна (ОХУ) нар. Энэ нь аливаад чамбай, тууштай хандаж, зорьсондоо хүрэхийн тулд махран зүтгэж чаддаг хөрш улсуудын санхүүгийн салбарын тэргүүлэгч хатагтай нарын гар нийлсэн хамтын ажиллагаа болсныг тэмдэглэх учиртай.



Нийгэмлэгийн Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилгын зөвлөлд Монгол, ОХУ-удаас гадна Казакстан, Киргизстан, Тажикстан, Узбекстаны Төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагууд гишүүнчлэгдэж байна. Санаачилгын зөвлөл бүс нутгийн санхүүгийн зохицуулагчид болон зах зээлийн хөгжилд шаардлагатай бодлого, зорилгыг нэгтгэн, үйл ажиллагааг зангидаж, сорилт туршлага, санал санаачилгыг уралдуулж ажиллах юм.

10 дахь Дэлхийн бодлогын чуулганы үеэр хуралдсан Захирлуудын зөвлөлийн 13 дахь

ээлжит хурлаар СХН-ийн өнгөрсөн 10 жилийн үйл ажиллагаа, зорилт, үр дүнг дүгнэж, ирэх жилийн бодлого, төлөвлөгөө, төсөв зардлыг хэлэлцэн баталсан. Энэ үеэр Захирлуудын зөвлөлийн дэд даргын сонгууль болсон бөгөөд СЗХ-ны дарга, доктор С.Даваасүрэн форумын хамтран зохион байгуулагч ОХУ-ын Төв банкыг Египетийн Төв банкны эсрэг нэр дэвшүүлсэн нь хөрш улсуудын гар нийлсэн ажиллагааг илтгэн харуулсан тактикийн ажиллагаа байлаа. Үүний дараа ОХУ-ын Төв банк нэрээ татаж авснаар Египетийн Төв банкны төлөөлөл Захирлуудын зөвлөлийн дэд даргын чиг үүргийг хэрэгжүүлэхээр болсон юм.



Сочигийн Дэлхийн бодлогын чуулганы бүхий

л үйл ажиллагааны хүрээнд оролцогчид СХН дэх Монгол Улсын оролцоо, нөлөө ихээхэн нэмэгдэж, идэвхжсэнийг илэрхийлж байсан юм. Ялангуяа санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд манай улсад харьцангуй дээгүүр, данс эзэмшилт зэрэг зарим үзүүлэлтээр хөгжилтэй орнуудын түвшинд явж буй болон жендерийн тэгш бус байдал огт байхгүй зэргийг талархан хүлээж авч байлаа. Доктор С.Даваасүрэн санхүүгийн инновацийн асуудлаар чуулганд илтгэл тавихдаа Монгол Улс дахь санхүүгийн хүртээмжийн зарим тоо баримтыг ишлэн жишээлсэн нь ихээхэн сонирхолтой баримтуудын нэг болсон юм.

Доктор С.Даваасүрэн илтгэлдээ, санхүүгийн зах зээл болон инноваци нь харилцан хамаарал бүхий хөгжлийн чухал хүчин зүйлс болохыг онол болон тоо баримт, судалгаанд тулгуурлан өгүүлж, үүний нэн тодорхой илрэл нь финтек юм гэдгийг онцлон тэмдэглэсэн юм. СХН-ийн гишүүн байгууллагууд хүн төрөлхтний нийт хүн амын дийлэнхийг төлөөлөн ажиллаж буйн хувьд дэвшилтэт технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж хөгжүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг тэлэх шаардлагатай

мөн тэрээр чухалчлан илтгэв.

Дэлхийн санхүүгийн бодлогын чуулган амжилттай, мөнхүү ихээхэн ач холбогдолтой болж өндөрлөв. Дараагийн чуулганыг Руанда Улсад хийхээр товлож, цан цохилоо. Мөн Захирлуудын Зөвлөлийн 14 дэх хуралдааныг энэ оны эцэст теле-хурал хэлбэрээр зохион байгуулахаар тогтов. Энэ удаагийн чуулганд оролцсон Монгол Улсын СЗХ-ны оролцоо, түүний үр дүнг дээр дурдсан томоохон үйл ажиллагааны зэрэгцээ ажлын хэсгүүдийн хуралдаанууд, төр-хувийн хэвшлийн дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт, бүсийн санаачилгын зөвлөлийн хуралдаан гэх мэт олон үйл явдал, тэдгээрийн үр дүнгээр хэмжих учиртай. Чуулганы үндсэн ажиллагаа болон салбар хуралдаанууд, хоёр талын ба олон талын уулзалтууд, энд болсон яриа хэлэлцээнүүдийн агуулгыг дүгнэвэл Сочигийн "дэвжээнд" Монгол Улс урьд өмнө огт үзүүлж байгаагүй амжилт гаргалаа гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй. Учир нь Сочигийн яриа хэлэлцээний мөрөөр хийгдэх ажлууд тун удахгүй ундарч, бодит үр дүнгүүд ар араасаа гарч эхэлнэ.

ХЭРЭГЛЭГЧ

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Иргэн "Б"-ээс 2018 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр гаргасан нэр бүхий ББСБ нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээллийг буруу оруулсанд гомдолтой байх тул шалгуулахыг хүсэж өргөдөл гаргасан байна. Уг өргөдлийг хуулийн дагуу хянаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд байх зээлдэгчийн мэдээлэл буруу байгааг тогтоон тухайн ББСБ-д албан бичгээр мэдээллийг залруулж, иргэн "Б"-г хохиролгүй болгох тухай хугацаатай үүрэг даалгавар өгч залруулан иргэний гомдлыг бүрэн шийдвэрлэв.

САЛБАРЫН ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэн "С"-ээс 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр нэр бүхий ББСБ-ууд салбарын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгааг шалгуулах тухай өргөдлийг ирүүлсэн байна. Өргөдлийн дагуу тус Хорооны улсын байцаагч газар дээр нь очиж үзлэг хийн салбарын зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа зарим ББСБ-уудын зөрчлийг хуулийн дагуу арилгуулж, иргэнд хариуг хүргүүлсэн байна.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ

Иргэн "А" нь даатгалын компани даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан учир Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 "аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг

Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно" гэж заасны дагуу өргөдөл бичиж Хороонд хандсан байна.

Өргөдлийн дагуу талуудаас тайлбар ирүүлж, нотлох баримтын хүрээнд асуудлыг хянахад, уг иргэний өмчлөлийн тээврийн хэрэгслийн арлын дугаарын нэг үсэг зөрүүтэй байсан гэсэн шалтгаанаар даатгалын компани даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан бөгөөд тээврийн хэрэгслийн бүртгэлийн нэгдсэн санд залруулга хийлгэснийг тодорхойлон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, Иргэний хуулийн 439 дүгээр зүйлийн 439.4-т тус тус заасныг тус тус үндэслэн иргэн "А"-д даатгалын нөхөн төлбөрийг олгуулахаар шийдвэрлэсэн байна.

"ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ" ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАЛААР

Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас өнгөрсөн хугацаанд "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд тус тус эзэмшүүлэх, 30 хувийг хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө босгох, мөн 1072 хувьцааг 1.0 сая төгрөгтэй дүйцүүлж, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон зэрэг шийдвэрийг гаргасан билээ. Мөн эдгээр шийдвэрүүдээр тус компанийн хувьцааг арилжиж эхлэх хүртэл иргэдийн нэр дээр бүртгээд буй хувьцаа нь саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлийг тогтоосон. Өнөөдрийн

байдлаар нийт 2,897,277 иргэн бүрийн нэр дээр "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн нийт хувьцааны 14.75 хувийг эзэмшүүлэхээр "ҮЦТХТ" ХХК дээр бүртгээд байна.

Эхний ээлжинд иргэд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид данс нээсэн эсэхээ мэдэхгүй байгаа тохиолдолд дараах байдлаар "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн хувьцаагаа шалгах боломжтой.

- www.schcd.mn цахим хуудсанд зочилж, регистрийн дугаарыг оруулах;
- "ҮЦТХТ" ХХК-д иргэний үнэмлэхтэй очих;
- **158989** дугаарт Мобиком, Юнител, Скайтал болон Жи мобайлын үүрэн

холбооны утаснаас регистрийн дугаараа мессежээр илгээх /Регистрийн дугаарын эхний хоёр үсгийг латинаар бичнэ/.

Хэрэв харилцах үнэт цаасны компанид данс нээлгэж байгаагүй бол Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий брокерын компаниудын аль нэгэнд хандаж дансаа нээлгэх боломжтой. Иргэд үнэт цаасны компаниар дамжуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид дансаа нээлгэснээр "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн хувьцаа эдийн засгийн эргэлтэд орох үеэс уг компанийн хувьцааны арилжаанд оролцох, ногдол ашгаа хүртэх зэрэг боломжтой болно.

"ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ" ХК-ИЙН ХУВЬЦААГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЭХДЭЭ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН САНГААС ХИШИГ ХУВЬ ХҮРТСЭН МӨНГӨН ДҮНГЭЭР ХАСАГДУУЛСАН БАЙДАЛ

"Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэхдээ Хүний хөгжлийн сангаас хишиг хувь хүртсэн мөнгөн дүнгээр хасагдуулсан тул иргэн бүрт харилцан адилгүй хувьцаа бүртгэгдсэн байдаг. Тухайлбал, дараах төрлөөр хишиг хувь хүртсэн иргэд хамрагдана:

- 2011 онд оюутны сургалтын төлбөр /500,000 төгрөг хүртэл/;
- 2012 онд оюутны сургалтын төлбөр /491,960 төгрөг хүртэл/;
- 2011 онд эрүүл мэндийн даатгал /8,040 төгрөг хүртэл/;
- Ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон 1 сая төгрөг хүртэл хэлбэрээр.

Хувьцааны үлдэгдлийг хэрхэн бодох вэ?

- Иргэн "А" 2011 онд эрүүл мэндийн даатгалын 8040 төгрөгийн хишиг хувь хүртсэн. 8040 төгрөгт ногдох хувьцаа:
 - $(1072 \cdot 8040) / 1000000 = 8.61888 \approx 9$;
 - Иргэн "А"-ийн эзэмших хувьцааны үлдэгдэл: $1072 - 9 = 1063$.
- Оюутан "Б" 2011 сургалтын төлбөр хэлбэрээр 500000, эрүүл мэндийн даатгал хэлбэрээр 8040 төгрөг нийт 508040 төгрөгийн хишиг хувь хүртсэн байна. 508040 төгрөгт ногдох хувьцаа:

- $(1072 \cdot 508040) / 1000000 = 544.618 \approx 545$;
- Оюутан "Б"-ын эзэмших хувьцаа: $1072 - 545 = 527$.
- Оюутан "В" 2012 сургалтын төлбөр хэлбэрээр 491960 төгрөгийн хишиг хувь хүртсэн байна. 491960 төгрөгт ногдох хувьцаа:
 - $(1072 \cdot 491960) / 1000000 = 527.3811 \approx 528$;
 - Оюутан "В" эзэмших хувьцаа: $1072 - 528 = 544$.
- Иргэн "Г" 2012/03/18 өдөр нас барсан /Монгол улсын харьяатаас гарсан/ бол:
 - Иргэн "Г"-ийн эзэмших хувьцаа: **536**.
- Иргэн "Д" Засгийн Газарт хувьцаагаа худалдаж 300 426 төгрөг авсан бол **322** ширхэг хувьцаа хасагдаж **750** ширхэг хувьцаа эзэмшинэ.
- Иргэн "Д" Засгийн Газарт хувьцаагаа худалдаж 200 284 төгрөг авсан бол **215** ширхэг хувьцаа хасагдаж **857** ширхэг хувьцаа эзэмшинэ.
- Иргэн "Д" Засгийн Газарт хувьцаагаа худалдаж 100 142 төгрөг авсан бол **108** ширхэг хувьцаа хасагдаж **964** ширхэг хувьцаа эзэмшинэ.

Харин Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн иргэдэд "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн хувьцаа олгогдохгүй юм байна.

Нэг зүйлийг онцлоход, зарим иргэд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид данс нээлгэсэн буюу үнэт цаасны компанийн харилцагч хэрнээ давхар данс нээлгэх

тохиолдлууд гарч байна. Тиймээс юуны түрүүнд хувьцаагаа шалгах, өөрийн мэдээллээ шалгасны дараа дансгүй бол дансаа нээлгэхийг зөвлөж байна.


Сүүлийн үед "Эрдэнэс-Таван толгой" компаниас хувьцааны ногдол ашиг тараана, эсхүл энэ ондоо амжиж бүртгүүлэхгүй бол болохгүй гэх зэрэг ташаа мэдээллүүд нь иргэдэд буруу ойлголтыг төрүүлж улмаар

данс нээхэд ачаалал үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн дунд яваад байгаа шиг хувьцааны дансаа нээлгэхгүй бол болохгүй, хугацаа нь дуусна гэсэн ойлголт байхгүй ба иргэдийн дансыг нээх үйл явц хэвийн үргэлжилж байгаа бөгөөд цаашид ч бүртгэсээр байх тул иргэд хэзээ ч хувьцаагаа шалгаж, дансаа нээлгэх эрх нээлттэй юм.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОП-20 ИНДЕКС 10.5 ХУВИАР ӨСЛӨӨ.


Энэ оны гуравдугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 12.8 хувиар өсөж 2.35 их наяд төгрөгт хүрсэн байна. Өнөөдрийн байдлаар нийт 304 хувьцаат компани, 54 үнэт цаасны компани тус зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ТОП-20 индекс өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсчээ. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХХК-аар дамжуулан гуравдугаар улиралд нийт 106.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 30.4 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 44.7 тэрбум төгрөгийн хувьцаа, 30.3 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас, компанийн 631.6 сая төгрөгийн бонд, МҮЦБ-ийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 279.6 сая төгрөгийн хувьцааг тус тус арилжаалсан байна.



ДААТГАЛЫН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ 16 ХУВИАР ӨСӨЖ 327.6 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЛЭЭ.

Даатгалын салбарын нийт хөрөнгийн 76.4 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 21 хувийг давхар даатгалын компани, 2.7 хувийг урт хугацааны даатгалын компаниуд бүрдүүлжээ.


Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 42.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 34.4 хувийг эзэлж байгаагаас ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.9 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 30.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант улиралд салбарын татварын дараах цэвэр ашиг 41 хувиар өсөж нийт цэвэр ашгийн хэмжээ 14.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 10 хувь, нийт хөрөнгийн өгөөж 4.7 хувь байна.



Банк бус санхүүгийн салбарын зээлийн үйлчилгээний хүртээмжийн өсөлт өндөр байгаа нь зээлийн нийлүүлэлтээс гадна технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч эхэлсэнтэй холбоотой байна.

Банк бус санхүүгийн салбарт энэ оны гуравдугаар улирлын байдлаар нийт 540 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагийн дийлэнх буюу 90.9 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт хөрөнгийн хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 32.7 хувиар өссөн ба 2018 оны эхний гурван улирлын туршид гучаас дээш хувийн өсөлтийг үзүүлээ. Хөрөнгийн өсөлтийн 74.1 хувь нь зээлийн өсөлтөөс бүрджээ.

Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оноос 2.1 дахин нэмэгдэж, 217 мянга, харилцагчдын тоо 1.5 саяд хүрсэн дүнтэй байна. Харин зээлийн бүтээгдэхүүний үнэ болох сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин 3 дугаар улиралд 3.3 хувьтай байгаа бөгөөд хүүгийн түвшин өмнөх улирлын түвшнээс өөрчлөгдөөгүй байна. Нийт орлогын хувьд өмнөх оноос 32.7 хувиар өсөж, 183.9 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт ашиг 68.3 хувиар өсөж, 73.5 тэрбум төгрөгт хүрчээ.




ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД 34.8 ХУВИЙН ӨСӨЛТТЭЙ АЖИЛЛАВ.

Энэ оны гуравдугаар улирлын байдлаар нийт 288 ХЗХ үйл ажиллагаа явуулсан ба хоршоодын нийт гишүүдийн тоо 61,881-д хүрсэн байна. Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ 192.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар өссөн байна.

Салбарын нийт цэвэр ашиг 4.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар өссөн байгаа бол нийт орлого 33.9 хувиар өсөж 29.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн салбарын нийт зээл өнгөрсөн оноос 32 хувиар өсөж 142.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 4.4 хувь буюу 6.2

тэрбум төгрөг болжээ. Нийт ХЗХ–дын 89.2 хувь буюу 257 ХЗХ нь нийт 134.5 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн бол үлдсэн 10.8 хувь буюу 31 ХЗХ нь хадгаламж татаагүй байна. Нийт хадгаламжийн 98.3 хувийг хугацаатай хадгаламж, бусад 1.7 хувийг хугацаагүй хадгаламж эзэлж байна.



2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2019 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 25

Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 13 жилийн ой

2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН ГУРАВДАХ ПҮРЭВ ГАРАГ

Хадгаламж, зээлийн хоршоодын олон улсын өдөр

2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24

Даатгалын өдөр

2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН 15

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдөр

2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31

Дэлхийн хуримтлалын өдөр

2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН ХОЁР ДАХЬ НЯМ ГАРАГ

Санхүү, эдийн засагчдын өдөр

2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН 2

Банкны салбарын ажилтны өдөр

2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 14

Зохицуулагч байгууллагын 25 жилийн ой



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо